

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**“ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨӨӨС БАРИМТЛАЖ БУЙ
БОДЛОГО, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”**

АУДИТЫН КОД: БУА-2024/20-04-ШТА-ГА

**БУЛГАН АЙМАГ
2024**

Булган дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ
Утас: 7034-2580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 7034-2716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор: П.Содном
Утас: 7034-2495 Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn
Аудитор: Д.Даариймаа
Утас: 7034-2716 Цахим хаяг: Daariimaad@audit.gov.mn
Аудитор: Б.Энхтөр
Утас: 7034-2716 Цахим хаяг: Enkhturb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. bulgan@audit.gov.mn

АГУУЛГА

<u>Товчилсон үгийн тайлбар</u>	5
Хүснэгтийн товъёг	6
Зургийн товъёг	7
<u>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</u>	

А. Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, тогтолцоо оновчтой эсэх?.....

А1.1. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГО, ТОГТОЛЦОО НИЙГМИЙН ХЭРЭГЦЭЭНД НИЙЦСЭН БАЙНА.....

А1.4 Хүүхэд хамгааллын чиглэлээр тусгасан зорилт, арга хэмжээ нь засгийн газрын болон аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцсэн байна..... 10

А1.6 Аймгийн хэмжээнд зохион байгуулсан уралдаанаас зөвхөн аймгийн баяр наадмын уралдаанч хүүхдийн бүртгэл хийсэн, хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн талаар тандалт судалгааг ажлууд дутуу хийгджээ.....10

А2. Хүүхэд хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагууд хүний нөөцийн хүртээмжтэй байдлыг хангаж, харилцан уялдаатай ажиллаж чадаж байна уу?

А1.2.1 Хүүхдийн төлөө зөвлөлийн хэлэлцсэн асуудал, гарсан тогтоол шийдвэр, хуралдааны талаарх тэмдэглэл, хуралдаанд оролцогчийн бүртгэл зэрэг баримт материал хангалтгүй байна.....11

А1.2.2. Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын газар хуулиар хүлээсэн зарим чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дүн шинжилгээ хийж, цаашид хэрэгжүүлэх ажлын чиглэлийг оновчтой тодорхойлох шаардлагатай байна.....13

А1.2.5. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, 108-н программ, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны хяналтад байгаа хүүхдийн мэдээлэл зэргийг тус тусын программд бүртгэдэг ба нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлж ажиллаагүй байна.....14

А1.2.6. Сумдад нийт 39 нийгмийн ажилтан ажиллаж байгаагийн 53.8 хувь мэргэжлийн бус байна.....15

Б. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙГ ҮР ӨГӨӨЖТЭЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ, ОНОВЧТОЙ БАЙХААР ТООЦОЖ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.....

Б1. Хүүхэд хамгааллын санхүүжилт нь хамгаалах, нөхөн сэргээх, хариу үйлчилгээний зардал хангалттай хүртээмжтэй байгаа боловч урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал хүрэлцдэггүй, төсвийн төлөвлөлтийг бодитой тооцоогүй мөн “Жаргалант” хүүхдийн зусланг 1.6 тэрбум төгрөгөөр шинэчлэн барьсан барилгыг ашиглалтад оруулсан байна.....16

Б1.1. Хүүхэд хамгаалалд зориулсан төсөв, зардлыг хийгдэх ажлыг хүрээнд хүүхэд хамгааллыг зардлыг төлөвлөж, үр дүнтэй зарцуулах, эрсдэлт бүлгийн хүүхэд бүрд хүртээмжтэй байхаар төлөвлөхөөр байна.....16

Б1.2. Хүүхэд хамгааллын төсөв хөрөнгө нь урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа болон хүүхдийн эрхийн зөрчлийн шалтгаан нөхцөлийг бууруулахад чиглэж байгаа боловч төсөв нь хүрэлцээгүй байна.....17

Б1.3. Хүүхэд хамгааллын чиглэлээр урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх, хариу үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа явуулахад 2019-2023 онуудад хүүхэд хамгааллын чиглэлээр 2 орон тоо батлагдаж шаардлагатай хүний нөөцийн хүрэлцээ дутмаг, албан хаагчид тогтвор суурьшилгүй, шаардлагатай зардлыг оновчтой хуваарилдаггүй байна.....21

Б2. Хүүхэд хамгаалалд төлөвлөсөн санхүүжилтийн гүйцэтгэл үр дүнтэй байгаа боловч 2019-2021 онуудад зардлын нормативыг мөрдөж ажиллаагүй цаашид санхүүгийн хяналтыг сайжруулах шаардлагатай байна.....22

Б2.1. Хүүхэд хамгааллын чиглэлээр зарцуулсан санхүүжилт, хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.....22

Б2.2. Хүүхэд хамгааллын төсвийн зарцуулалтыг байгууллагын шилэн дансанд ил тод байдлыг ханган ажиллажээ.....22

Б2.3. Хүүхэд хамгааллын талаар Австрали улсын MNO095 төсөл хөтөлбөрийн хүрээнд түр хамгаалах байр барих төсөл бичиж шалгарснаар 18.7 мянган Австрали долларын буцалтгүй тусламж авчээ.....22

Б2.4. Хүүхэд хамгааллын цогц үйлчилгээг хангалттай сайн хүргэсэн байна.....23

Б2.5. Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хүүхдийн хувь хүний нууц бүрэн хамгаалагдахгүй байна.....25

Б2.6. Хүүхэд хамгааллын үйлчилгээний урьдчилсан сэргийлэх үйлчилгээний төсвийг 2022-2023 онд хөтөлбөр арга хэмжээгээр баталж өмнөх онуудад бөөн дүнгээр баталж байсан бол хариу үйлчилгээ үзүүлэх төсвийг тусгайлан оновчтой хуваарилалт хийж батлаагүй байна.....26

В3. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНД ХЯНАЛТ, ҮР НӨЛӨӨТЭЙ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.....26

В.3.1. Хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдал, хууль журмын хэрэгжилтийн талаар судалгаа шинжилгээ хийж, цаашид үйл ажиллагаандаа ашиглах шаардлагатай байна.....27

В.3.1.1. Оролцогч талуудын үйл ажиллагааг үнэлж, дүгнэх аргачлал байхгүй, хийж хэрэгжүүлсэн ажлыг эерэг, сөрөг нөлөөллийг тодорхойлсон баримт материал байхгүй байна.....27

В.3.1.2. Аймгийн хэмжээнд ХГБХХГ-аас хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдал, хууль журмын хэрэгжилтийн судалгаа, хяналт-үнэлгээ хийдэггүй байна..28

В.3.1.3. Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр олон улсын байгууллагуудаас өгсөн зөвлөмжийн талаар орон нутгийн хүүхдийн байгууллагаас хэрэгжилт гаргасан баримт бичиггүй байна.....29

В.3.1.4. Хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжсэн төсөл нь үр дүнтэй ажил болсон байна.....29

В.3.1.5. Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл нь 2023 онд аймгийн хэмжээнд 22 сургууль, 22 цэцэрлэгүүдийн хүүхэд хамгааллын үйлчилгээ, бодлого, төлөвлөгөө, хэрэгжилтэд хяналт тавьж зөвлөгөө өгч ажилласан байна.....29

В.3.1.6. Аймгийн хэмжээнд 68 байгууллага хүүхэд хамгааллын бодлоготой ба хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг бодитой үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлал байхгүй байна.....30

В.3.1.7. Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг бодитой үнэлж нийгэмд гарч буй эерэг нөлөөг тооцож үнэлээгүй байна.....30

В.3.2. ГЭР БҮЛИЙН ОРЧИНД ҮЙЛДЭГДЭЖ БАЙГАА ХҮҮХДИЙН ЭРХ, ХАМГААЛЛЫН ЗӨРЧЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР СУРГАЛТ, НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.....30

В.3.2.1. Хүүхдийн эрх, хамгааллын зөрчлийн 75.4 хувь нь гэр бүлийн орчинд гарсан байна.....30

В.3.2.2. Аймгийн боловсролын салбарын байгууллагууд хүүхдэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн ажиллажээ.....31

В.3.2.3. Эрүүл мэндийн салбарт хүүхэд хамгааллын талаар хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан тоо, мэдээлэл байхгүйтэй холбоотой үнэлэх боломжгүй байна.....32

В.3.2.4. Хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчин дахь хүүхэд хамгааллыг эрчимжүүлэх, энэ чиглэлийн ажлыг нэмэгдүүлэхэд холбогдох зардал тусгагдаагүй байгааг анхаарах шаардлагатай байна.....33

В.3.2.5. Олон нийтийн арга хэмжээ оролцож буй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс оролцуулах талаар бичгээр зөвшөөрөл аваагүй байна.....33

В.3.2.6. Гамшгаас хамгаалах тусгай зориулалтын мэргэжлийн ангид нийгмийн хамгааллын мэргэжлийн анги байгуулж сургалт, дадлагын ажилд хамруулсан байна.....34

В.3.3. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ СУРГАЛТ, НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫН ҮР ДҮНГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.....35

В.3.3.1. Хүүхдийн эрхийн олон улсын конвенцын талаар сурталчлан таниулж байна.....35

В.3.3.2. Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлагад үндэслэн хүүхдийн эрх, хамгаалал ямар орчинд аль төрлийн хэрэг, зөрчил гарч байгаа талаар мэдээлэлд дүн шинжилгээ хийгээгүй байна.....36

В.3.3.3. Хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн систем байхгүйгээс хүүхэд хамгааллын үйлчилгээний талаарх мэдээллийг цаг тухай бүрд судлах үр дүнг үнэлэх, цаашид үзүүлэх үйлчилгээг оновчтой төлөвлөх зэрэгт бэрхшээл үүсэж байна.....37

В.3.3.4. Бүртгэгдсэн дуудлага, хэрэг зөрчлийн талаарх нөхцөл байдалд судалгаа, шинжилгээ хийж цаашид хийх ажлын чиглэлийг тодорхойлсон баримт материал байхгүй байна.....38

В.3.3.5. Салбар бүр хүүхэд хамгаалалтай холбоотой тоон үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөж, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай байна.....	39
ДҮГНЭЛТ.....	39
ЗӨВЛӨМЖ.....	40

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ХГБХХГ	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар
ЦГ	Цагдаагийн газар
ОБГ	Онцгой байдлын газар
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрийн төв
ЕБС	Ерөнхий боловсролын газар
НБҮ	Нэгдсэн үндэсний байгууллага

Хүснэгтийн товчлол

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Уралдаанч хүүхдийн бүртгэл	10
Хүснэгт 2	Төлөвлөсөн арга хэмжээ, хэрэгжилт тоогоор	11
Хүснэгт 3	Зохион байгуулж, хэрэгжилтийг тооцсон хүснэгт	12
Хүснэгт 4	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн бүртгэл	13
Хүснэгт 5	Хүүхэд хамгааллын цахим системийн бүртгэлийн мэдээлэл	14
Хүснэгт 6	Эрсдэлт бүлгийн хүүхдийн тоо, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зарцуулсан төсөв	17
Хүснэгт 7	Цагдаагийн газарт бүртгэгдсэн насанд хүрээгүй хүн хохирсон гэмт хэрэг	18
Хүснэгт 8	Насанд хүрээгүй хүн холбогдсон гэмт хэргийн эрүүгийн хуульд заасан бүлгээр авч үзвэл	19
Хүснэгт 9	2019-2023 онд 108 дугаарт ирсэн дуудлага	23
Хүснэгт 10	Хүүхдийн тусламжийн утас 108 дуудлага	28
Хүснэгт 11	Иргэдээс ирсэн санал, гомдол дуудлага	31
Хүснэгт 12	Гамшиг, осолд өртсөн хүүхдийн судалгаа	34-35
Хүснэгт 13	Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлагыг сум тус бүрээр	36
Хүснэгт 14	Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлагыг орчныг авч үзвэл	36
Хүснэгт 15	Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн зөрчил	37
Хүснэгт 16	Насанд хүрээгүй хүн холбогдсон гэмт хэргийн тоо, мэдээлэл	37

Графикийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	Хүүхэд хамгааллын батлагдсан төсөв, зарцуулсан төсөв	16
График 2	Гэмт хэрэгт хохирсон хүүхэд	18
График 3	Гэмт хэрэгт холбогдсон хүүхэд	20
График 4	Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо	20
График 5	Цагдаагийн газарт бүртгэгдсэн хүүхдэд ХГБХХГ-аас хамгаалах үйлчилгээ үзүүлэх, шилжүүлэн авсан	21
График 6	Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ авсан хүүхэд, эрсдэлт бүлэгт байгаа хүүхэд	24

Зургийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Хүүхэд хамгаалах түр хамгаалах байрны дотор тохижилтын зураг	22-23

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3, 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2023 “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Булган аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэв.
Аудитын зорилт	Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт болон бий болсон үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан Улсын Их Хурлын байнгын хороо, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго оршино. Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд: • Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, төлөвлөлтийн тогтолцоо оновчтой эсэх • Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөлт, төсөвлөлт үр өгөөжтэй, хүүхдэд ээлтэй байж чадсан эсэх. • Хүүхэд хамгааллын талаар баримталж буй бодлогын хэрэгжилт үр дүнтэй эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Хүүхэд хамгааллын тухай хуулийн хүрээнд хүүхэд хамгааллын чиглэлээр, үйл ажиллагаанд оролцдог төрийн болон төрийн бус байгууллагуудын 2019-2023 оны баримт, мэдээллийг хамруулан аудитыг гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж, аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд суурилан дүгнэлт өгч, зөвлөмж боловсрууллаа.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ удирдан, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол хэрэгжүүлж, ахлах аудитор П.Содном, аудитор Д.Даариймаа, Б.Энхтөр нар төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлийн аудитын талбарын ажлыг 2024 оны 08 дугаар сарын 20-ний өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 01-ны өдөр хүртэл гүйцэтгэж, тайлагналын ажлыг 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр дуусгавар болгон аудитыг үе шатны хяналтаар хянуулж, аудитын тайлан, нотлох баримтыг бэлтгэж ажиллалаа.

**Хүндрэл
бэрхшээл**

Сонгуультай холбогдуулан суманд ажиллах, аудиттай холбогдох ажилтнууд сонгуулийн ажилтай, үед таарсан учир цаг хугацаандаа аудитад шаардлагатай баримт материал авах хүндрэлтэй байлаа.

хүүхэд хамгааллын чиглэлээр тусгасан зорилт, арга хэмжээ нь засгийн газрын болон аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцсэн байна.

1.1 ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГО, ТОГТОЛЦОО НИЙГМИЙН ХЭРЭГЦЭЭНД НИЙЦСЭН БАЙНА.

1.1.4 ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ТУСГАСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ НЬ ЗАСГИЙН ГАЗРЫН БОЛОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТЭЙ НИЙЦСЭН БАЙНА.

“Алсын хараа 2050”-ийн Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2-т, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.8-д “Гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүх бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ” гэсэн заалтуудтай нийцүүлэн аймгийн Засаг даргын 2016-2020 оны “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрт хүүхэд хамгаалалтай холбоотой 8, 2020-2024 оны аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөрт хүүхэд хамгаалалтай холбоотой дараах 4 зорилт хэрэгжүүлэхээр тусган хэрэгжүүлэн ажиллажээ.

Үүнд:

- Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргасан санал, санаачилгыг дэмжих.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдэд зориулсан чөлөөт цагаа өнгөрөөх, нийгэмшүүлэх, сэргээн засах эмчилгээ, сувилгааны зориулалтаар “Хөгжлийн төв” байгуулах.
- Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд хамгааллын чиглэлээр эрх нь зөрчигдсөн иргэдийг хамгаалах “Хүчирхийллээс хамгаалах түр байр”-ны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.
- Хүүхдийн “Жаргалант” зуслангийн барилга, байгууламжийг үе шаттайгаар барих.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хүүхэд хамгаалалтай холбоотой тусгасан ажлыг хэрэгжүүлэхээр ХГБХХГ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Шинэ хөгжлийн зам” мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажил болон тусгагдаж хагас, бүтэн жилээр тайлагнан ажиллажээ.

1.1.6 Аймгийн хэмжээнд зохион байгуулсан уралдаанаас зөвхөн аймгийн баяр наадмын уралдаанч хүүхдийн бүртгэл хийсэн, хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн талаар тандалт судалгааг ажлууд дутуу хийгджээ.

Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө (2018-2019)-ний 4.3.2, 4.3.3 заалтыг хэрэгжүүлэх Хурдан морь уралдаанч хүүхдүүд, хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн эрхийг хамгаалах талаар судалгаанд суурилсан үр дүнд чиглэсэн ажлыг хамтран зохион байгуулах ажил жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан боловч 2019, 2020, 2021 онуудад хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн талаар тандалт судалгаа хийгээгүй,

2022 онд 1, 2023 онд 2 удаа хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн эрхийг хамгаалах талаар хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчаар ахлуулсан ажлын хэсэг

төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулж ажилласан ба 2023 онд хяналт шалгалт хийсэн 37 байгууллагад хяналт шалгалт хийхэд зөрчил илрээгүй, 2022 оны хяналт шалгалтаар хөдөлмөрийн гэрээгээр 2 хүүхэд ажиллуулж байсан зөрчлийг илрүүлэн гэрээг цуцлуулсан байна.

Хичээл завсардан хөдөлмөр эрхэлж байсан 1 хүүхдийг Булган сумын хамтарсан баг бусад талуудтай хамтран ажиллаж Улаанбаатар хот дахь коллежид холбон зуучлан боловсролын үйлчилгээнд хамруулан ажилласан байна.

Аймгийн ХГБХХГ нь хурдан морины уралдаанд оролцож буй уралдаанч хүүхдийн насанд хүрсэн эсэх, даатгал хийгдсэн эсэх, сургуульд сурдаг эсэх, хэдэн насны морь унах, эцэг эхийн зөвшөөрлийн мэдээллийг бүртгэл хийж хяналт тавих үүрэгтэй.

Хүснэгт № 1 Уралдаанч хүүхдийн бүртгэл

№	Он	Уралдааны тоо	Уралдаанч хүүхдийн тоо	Нас	Эцэг эхийн зөвшөөрөл	Даатгал	Сургуулийн хамрагдалт
1	2019	14	194	194	194	194	194
2	2020	15	306	306	306	306	306
3	2021	1	74	74	74	74	74
4	2022	1	132	132	132	132	132
5	2023	1	111	111	111	111	111

2021, 2022 онуудад аймгийн наадмаас бусад уралдааны уралдаанч хүүхдийн бүртгэлийг бүртгээгүй, 2023 онд улсын баяр наадмаас гадна 3 удаагийн морины уралдаанд 76, аймаг сумын 18 удаагийн баяр наадмын уралдаанд 653 хүүхэд хурдан морь унаж уралдсан боловч уралдаанч хүүхдийн бүртгэлд аймгийн наадмаас бусад уралдаан бүртгэгдээгүй байгаа нь уралдаанч хүүхдийн бүртгэл сүүлийн 3 жил сумдын баяр наадам, хурдан морины өвөл, хаврын уралдаанд хориглосон насны хязгаарт хяналт тавих, зөвшөөрөгдсөн уралдааны үед хүүхдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах ажил дутуу хийгдсэн гэж үзэхээр байна.

1.2.1 Хүүхдийн төлөө зөвлөлийн хэлэлцсэн асуудал, гарсан тогтоол шийдвэр, хуралдааны талаарх тэмдэглэл, хуралдаанд оролцогчийн бүртгэл зэрэг баримт материал хангалтгүй байна.

Хүүхдийн төлөө орон нутгийн зөвлөл нь хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хүүхэд хамгаалал, хөгжлийн үйл ажиллагааны талаар холбогдох төрийн байгууллагад чиглэл, хуулийн этгээдэд зөвлөмж өгөх зэрэг үүргийг хүлээдэг.

Хүүхдийн төлөө зөвлөлийг аймгийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/113 дугаар захирамжаар зөвлөлийн дарга, 15 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталсан байна.

Хүүхдийн төлөө зөвлөл нь жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан гаргаж ажилласан байна.

Хүснэгт № 2 Төлөвлөсөн арга хэмжээ, хэрэгжилт тоогоор

№	Он	Төлөвлөсөн арга хэмжээ тоо	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Хэрэгжилт /хувь/	Тайлбар
1	2019	13	13	100	
2	2020	32	29	90	
3	2021				Төлөвлөгөө, тайлан гаргасан ирүүлээгүй материал
4	2022	18	15	83	
5	2023	19	19	100	

Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл нь 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 13 ажил, 2020 онд 4 зорилтын хүрээнд 32 ажил, 2022 онд 3 зорилтын хүрээнд 18 ажил, 2023 онд 3 зорилтын хүрээнд 19 ажил хийхээр төлөвлөж хэрэгжилт 83-100 хувийн биелэлттэй тайлагнасан байна. Харин 2021 онд зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан гаргаж ажиллаагүй байна.

ХГБХХГ -ийн үйл ажиллагааны тайланд зөвлөл нь 2019 онд 5, 2020 онд 3, 2021 онд хуралдаагүй, 2022 онд 3, 2023 онд 3 удаа хуралдсан гэх боловч хэлэлцсэн асуудал, гарсан тогтоол шийдвэр, хуралдааны талаарх тэмдэглэл, хуралдаанд оролцогчийн бүртгэл зэрэг анхан шатны баримт материал байхгүй, байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад зөвлөлийн үйл ажиллагааны талаарх бүртгэсэн архивын нэгж байхгүй байна.

Аймгийн хүүхдийн төлөө зөвлөлийн дүрмийн 2.1.4-д “зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь Зөвлөлийн хурал байна. Зөвлөл хуралдсан асуудлаараа тогтоол гаргаж биелэлтийг хангуулна. Зөвлөлийн тогтоол нь дарга нарийн бичиг гарын үсэг зурснаар баталгаажна.”; “2.1.5-д “Нийт гишүүдийн тоо 50 хувьд хүрсэн тохиолдолд зөвлөлийн хурлыг явуулна.”; “2.1.7-д “Зөвлөл нь ажлаа жилээр төлөвлөж хэрэгжүүлэх ба хагас жилд 1 удаа хуралдана. Шаардлагатай үед өргөтгөсөн болон ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулж болно. Хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг урьдчилан гаргаж, гишүүдэд хүргэсэн байна.” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй зөвлөлийн ажлын алба үүргээ хангалтгүй биелүүлжээ.

Мөн Аймгийн хүүхдийн төлөө зөвлөл аймгийн ИТХ-д танилцуулга хийж ажиллаагүй нь зөвлөлийн дүрмийн “2.1.10-д “Зөвлөл нь жилд 1 удаа /бүтэн жилээр/ аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдэд ажлаа тайлагнана” Хүүхэд хамгааллын тухай

хуулийн 21.3-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан өөрийн нутаг дэвсгэр дэх хүүхэд хамгааллын талаар тухайн шатны хүүхдийн төлөө зөвлөлийн тайлан, Засаг даргын саналыг хэлэлцэж, орон нутгийн төсөвт тусган, хэрэгжүүлэх арга хэмжээг авна.” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Харин Хүүхдийн төлөө зөвлөл нь 2019-2023 онд 2 албан даалгавар, 1 чиглэл гаргасан байна. Үүнд 2020 онд “хүүхдийн эрхийг хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх” тухай 3 байгууллагад 18 заалт бүхий албан даалгавар, 2022 онд “хүүхдийн эрх, хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ажил эрчимжүүлэх” тухай 5 байгууллагад 24 заалт бүхий албан даалгавар гаргаж хүргүүлснээс 2020 оны албан даалгаврын биелэлтийг ХГБХХГ хариуцах, хяналт тавьж ажиллахыг аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэст даалгасан ч биелэлтийн тайлан, хэрэгжилтийг тооцсон баримт материал байхгүй байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 01/1404 дугаар чиглэлийг гаргахдаа хүүхдийн өмнө тулгамдаж буй асуудлыг аймгийн бодлого шийдвэрт тусгах, хүүхдийн асуудал сонсох өдрийг 16 сум 1 тосгоны хүүхдийн төлөөллийг оролцуулан зохион байгуулж, гарсан саналуудыг нэгтгэн 8 ажил болгон сумын Засаг дарга бөгөөд Хамтарсан багийн ахлагч нарт хүргүүлэн хэрэгжилтийг тооцон ажилласан байна. /Хавсралт 1/

Тус чиглэлийн хүрээнд “Эрсдэлт орчин- Хүүхэд хамгаалал” аяныг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулж, хяналт шалгалтын ажлын хэсэг 16 сум, 1 тосгонд ажилласан ба ажлын хэсгийн бүрэлдэхүүнд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрхзүйн хэлтэс болон хүүхдийн төлөө зөвлөлийн гишүүн байгууллагын төлөөлөл болох Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Онцгой байдлын газар, Боловсрол шинжлэх ухааны газар, Цагдаагийн газар, Стандартчилал хэмжил зүйн хэлтэс, Хүнс хөдөө, аж ахуйн газрын мэргэжилтнүүд ажиллаж хэрэгжилтийг дүгнэсэн байна. Уг аян нь хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд бодитой үр дүн үзүүлсэн ажил болсон байна.

Аймгийн хэмжээнд сумын бүрд хүүхдийн төлөө зөвлөлийг байгуулсан ч үйл ажиллагаа нь тогтмолжиж, төлөвлөгөө, тайлан гаргаж ажиллаагүй байна.

1.2.2 Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын газар хуулиар хүлээсэн зарим чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дүн шинжилгээ хийж, цаашид хэрэгжүүлэх ажлын чиглэлийг оновчтой тодорхойлох шаардлагатай байна.

Хүүхдийн эрсдэлийн программ /Able/-д бүртгэлтэй хүүхдийн мэдээллийг сумын хамтарсан багтай хамтран шинэчилж насанд хүрсэн хүүхдийг хасаж, нөхцөл байдлын үнэлгээ хийгдэж нэмэгдсэн хүүхдийг бага, дунд, өндөр эрсдэлтэйгээр ангилан, гэр бүлийн байдал, хүүхдийн нас хүйс, эрүүл мэндийн байдал зэрэг мэдээллүүдийг оруулан бүртгэдэг байна. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн бүртгэлийн “Able” программыг 2024 оноос ашиглахаа больж, аймгийн ХГБХХГ

өөрсдөө Excel программаар файл үүсгэн одоогийн байдлаар 410 эрсдэлт бүлгийн хүүхэд бүртгэлтэй байна.

Хүснэгт № 3 Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн бүртгэл

Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023
Нийт хүүхдийн тоо	1092	446	441	414	425
Шинээр нэмэгдсэн хүүхдийн тоо	6	105	14	143	1
Хасагдсан хүүхдийн тоо	652	110	41	132	
Хариу үйлчилгээ үзүүлсэн хүүхдийн тоо	4	1021	732	546	127

ХГБХХГ нь 2019 онд 4, 2020 онд 1021, 2021 онд 732, 2022 онд 546, 2023 онд 127 хүүхдүүдэд хүнсний, амин дэмийн, ариун цэврийн, хичээлийн хэрэгслийн, түлээн нүүрсний дэмжлэг олгож, эрсдэлийн цогц даатгалд хамруулж, цахим хичээлээ үзэж чадахгүй байгаа хүүхдүүдэд датаны дэмжлэг үзүүлсэн боловч уг хариу үйлчилгээг үзүүлж буй хүүхдүүд эрсдэлт бүлгийн программд бүртгэлтэй хүүхдүүдээс цөөн хүүхэд хамрагдаж дийлэнх хүүхдийг үйлчилгээ үзүүлэх бүрд нөхцөл байдлын үнэлгээ шинээр хийж олгосон байна.

Энэ нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18.2.5-т “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаарх мэдээллийн сан бүрдүүлж үйл ажиллагаандаа ашиглах, бүртгэл, статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан аргачлалын дагуу эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн халамж, хамгаалал үйлчилгээний талаар бүртгэл хөтөлж, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;” гэсэн заалтын дагуу эрсдэлийн бүртгэлийн программын шинэчлэлийг үр дүнтэй хийгддэггүй, үйл ажиллагаандаа ашигладаггүй, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн халамж, хамгаалал үйлчилгээний талаар бүртгэл хөтлөөгүй байна.

Мөн хуулийн 18.2.1-т "нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхэд хамгааллын талаарх мэдээлэл, судалгаанд нэгдсэн дүгнэлт хийж, цаашид хийх ажлын чиглэлийг тодорхойлох" гэж заасныг бүрэн хэрэгжүүлдэггүй ба хүүхэд хамгааллын мэдээлэл, судалгаанд дүн шинжилгээ хийдэггүй, цаашид хийх ажлын чиглэлийг оновчтой тодорхойлоогүй байна.

1.2.5 Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, 108-н программ, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны хяналтад байгаа хүүхдийн мэдээлэл зэргийг тус тусын программд бүртгэдэг ба нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлж ажиллаагүй байна.

Аймгийн ХГБХХГ нь 2019-2023 онд статистик мэдээний маягт 2 удаа өөрчлөгдсөн ба Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын даргын 2021 оны 05 дугаар сарын 12-ны А/55 тоот тушаалаар батлагдсан Гэр, бүл, хүүхэд залуучуудын үйлчилгээний тоон мэдээ авах маягтаар мэдээ гаргаж байна.

2019, 2020, 2021, 2022 оны статистик мэдээ архивын нэгж үүсгээгүй, 2023 оны статистик мэдээг архивласан байна.

Хүүхэд хамгааллын үйл ажиллагааны мэдээллүүдийг дараах мэдээллийн сангуудад тус тусад нь бүртгэл хийдэг ба мэдээллийн нэгдсэн сан байхгүй байна.

Хүснэгт № 4 Хүүхэд хамгааллын цахим системийн бүртгэлийн мэдээлэл

Цахим систем	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
108.mn	42	48	60	95	83
able.mn Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд	1092	446	441	414	425
able.mn уралдаанч хүүхэд	194	306	74	132	111

“Able” программд эрсдэлт бүлгийн хүүхдийн бүртгэлийг хүүхдийн мэдээллийг сумын хамтарсан багтай хамтран жил тутамд шинэчилдэг. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийг эрсдэлийн программд бага, дунд, өндөр эрсдэлтэйгээр ангилан, гэр бүлийн байдал, хүүхдийн нас хүйс, эрүүл мэндийн байдал зэрэг мэдээллүүдийг оруулдаг. Уг бүртгэл нь 2024 оноос ашиглахаа больж аймгийн ХГБХХГ өөрсдөө Excel программаар файл үүсгэн ашиглаж одоогийн байдлаар 410 эрсдэлт бүлгийн хүүхэд бүртгэлтэй байна.

Зорилтот болон зорилтот бус дуудлагыг бүртгэж, утсаар зөвлөгөө өгөх, холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх, хүүхдийн эрхийн мэдээлэл зөвлөгөө өгөх 108 утсанд ирсэн дуудлага мэдээллийн хариу үйлчилгээнд хүүхэд хамгааллын мэргэжилтэн, хяналт тавьж 108-н программд бүртгэл хөтөлдөг байна.

1.2.6 Сумдад нийт 39 нийгмийн ажилтан ажиллаж байгаагийн 53.8 хувь мэргэжлийн бус байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 30-ын өдрийн А/71 дугаар тушаалаар 19 орон тоотойгоор удирдлага 1, гүйцэтгэх албан тушаалтан 14, түр хамгаалах байр 1, үйлчилгээний ажилтан 3 орон тоотойгоор баталжээ.

Аймгийн ХГБХХГ нь хүүхэд хамгаалал, нөхөн сэргээх, шуурхай тусламжийн үйлчилгээгээ түлхүү үзүүлээд, урьдчилан сэргийлэх, сургалт, бусад ажлаа хийх орон тооны хүрэлцээ муу, түр хамгаалах байранд ажиллах нийгмийн ажилтны орон тооны хүрэлцээгүйн улмаас хүүхдийн байцаагч нар дуудлага гарах үед түр хамгаалах байранд шөнө илүү цагаар ээлжлэн ажиллах нөхцөл үүссэн байна.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 28-ний өдрийн А/188 дугаар тушаалаар нийт орон тоог 27 болгож нэмж баталснаар шийдвэрлэгдсэн байна.

Орон тоо нэмж батлагдсаны дагуу түр хамгаалах байрны 5 ажилтан нэмж авсан ба бусад орон тооны ажлын байрны тодорхойлолт батлагдаж ирээгүй байна.

Сум, сургууль, багийн нийгмийн ажилтны 43 орон тоо байгаагаас Хялганат тосгон, Орхон, Тэшиг сумын нийгмийн ажилтны орон тоо сул, Рашаант сумын нийгмийн ажилтан хүүхэд харах чөлөөтэй байна. Ажиллаж байгаа 39 нийгмийн ажилтны 21 буюу 53.8 хувь нь мэргэжлийн бус ажилтан байна. Эдгээр ажиллаж байгаа ажилтны мэргэжлээр нь задалж үзвэл багш 5, менежер 3, нягтлан 2, эрх зүйч 3, биотехнологич 1, орчуулагч 1, улс төрч 1, экологи байгаль судлаач 1, Монгол, Хятад судлаач 1, Боловсрол судлаач 1 нийт 21 хүн байна. /Хавсралт 2/

Энэ нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Хүүхэд хамгааллын чиглэлээр үйлчилгээ үзүүлж байгаа төрийн байгууллага болон хуулийн этгээд тусгайлан бэлтгэгдэж, мэргэшсэн хүний нөөцтэй байна” гэж заасантай нийцэхгүй байна.

2. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙГ ҮР ӨГӨӨЖТЭЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ, ОНОВЧТОЙ БАЙХААР ТООЦОЖ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.

2.1. Хүүхдийн “Жаргалант” зусланг 1 тэрбум 622.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад оруулжээ.

2.1.1 Хүүхэд хамгаалалд зориулсан төсөв, зардлыг хийгдэх ажлыг хүрээнд хүүхэд хамгааллыг зардлыг төлөвлөж, үр дүнтэй зарцуулах, эрсдэлт бүлгийн хүүхэд бүрд хүртээмжтэй байхаар төлөвлөх.

Хүүхэд хамгааллын тухай хууль батлагдсанаар МУЗГ хүүхэд хамгаалалд зориулсан төсвийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд шилжүүлж, харин яам Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар шилжүүлж иржээ.


Хүүхэд хамгааллын үйлчилгээнд зориулсан төсөв, зардлыг судалгаанд үндэслээгүй, өмнө жилийн төсвийн гүйцэтгэлтэй уялдуулан төлөвлөжээ.

Хүүхдийн тусламжийн утасны дуудлага 2019-2022 онд 90 орчим хувиар өссөн бол харин 2023 онд 40 хувиар буурчээ, түр хамгаалах байраар 2019-2022 онд 134 үйлчлүүлэгч нийт 919 хоног хамгаалуулах үйлчилгээ авч байсан бол 2023 онд 64 үйлчлүүлэгч 150 хоногийн хамгаалуулах үйлчилгээг авсан байна.

Булган аймгийн ХГБХХГ-ын хүүхэд хамгааллын чиглэлээр баталсан санхүүжилтийг хөтөлбөр арга хэмжээгээр нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр 124.0 сая, хүүхэд хамгаалал 58.08 сая, эрсдэлийн болон НБҮ хийхэд 10.4 сая, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ 118.2 сая, урьдчилан сэргийлэх арга хэмжээ 83.2 сая төгрөгийг “Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.4¹ заалтын дагуу сүүлийн 5 жилд нийт 394.6 сая төгрөгийг баталж үл хайхрах байдал, дарамт, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түр хамгаалах байр, хүүхэд хамгааллын үйлчилгээ, хариу үйлчилгээ үзүүлэхэд 393.7 сая төгрөгийг нийт зарцуулсан байна.

График №1

¹ “Төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийг шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлах”



Тухайн жилүүдэд хүүхэд хамгааллын чиглэлээр баталсан урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсөв нь үйлчилгээ үзүүлэхэд хангалттай хүрэлцдэггүйгээс гэр бүл асран хамгаалагчид хийх нөлөөллийн ажил, сургалт сурталчилгаа дутмаг байсан байна.

Булган аймгийн хүүхдийн “Жаргалант” зусланг шинэчлэн барихад улсын төсвийн 920.0 сая, Эрдэнэт үйлдвэрийн 407.0 сая, орон нутгийн хөгжлийн сангаас 295 сая нийт 1 тэрбум 622.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 300 хүүхдийн хоолны заал, захиргаа аж ахуйн барилгыг ашиглалтад оруулахад зарцуулсан байна.

"Жаргалант" зуслан нь 2024 оны 1, 2-р ээлжиндээ Булган, Хөвсгөл, Орхон аймгийн нийт 160 гаруй амрагч хүүхдүүдийг хүлээн авч, үйл ажиллагаагаа явуулж байна.

2.1.2 Хүүхэд хамгааллын төсөв хөрөнгө нь урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа болон хүүхдийн эрхийн зөрчлийн шалтгаан нөхцөлийг бууруулахад чиглэж байгаа боловч төсөв нь хүрэлцээгүй байна.

Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газраас гэр бүлийн боловсрол олгох, хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэр бүл төлөвлөлтийн 6 модуль сургалтыг жилд хоёр удаа зохион байгуулж байна. Хийгдэх сургалт нь:

- Гэр бүлийн хүчирхийлэл
- Бэлгийн хүчирхийлэл
- Гэр бүл төлөвлөлт
- Гэр бүлийн эрүүл мэнд боловсрол
- Гэр бүлийн угийн бичиг
- Гэр бүлийн санхүүгийн боловсрол


Гэр бүлийн аюулгүй байдал, эрүүл тайван амьдрах орчин бий болгох уг сургалтад зориулсан төсөв батлагдаагүй аймгийн төвд албан байгууллагад үнэ

төлбөргүйгээр хийдэг бол хөдөө сумдад мөн үнэ төлбөргүй сургалтыг зохион байгуулж ажилдаг байна.

Гэмт хэрэг, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажилд 2019-2021 онуудад тусгайлан төсөв баталдаггүй байсан ч хүүхэд хамгааллын зардлаас үзэхэд 41.0 сая төгрөгийг төлөвлөж 37.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй бол 2022-2023 онуудад урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал 83.2 сая төгрөгийг баталж 83.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй боловч урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсөв хүрэлцдэггүйгээс төлөвлөсөн ажлын цар хүрээг нэмэгдүүлэх боломжгүй байна.

*Эрсдэлт бүлгийн хүүхдийн тоо, урьдчилан сэргийлэх арга
хэмжээний зарцуулсан төсөв*

Хүснэгт №6



Хүүхэд хамгааллын чиглэлээр урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэл, зөвлөмжийг олон нийтэд түгээх байдлаар “Сайхан Монгол” ТВ-тэй гэрээ байгуулж шууд дамжуулалт болон телевизийн контентыг тогтмол хуваарийн дагуу иргэд олон нийтэд мэдээлж, мөн гэр бүлийн радио 106.5 FM-ээр гэр бүлийн аюулгүй байдал, хүүхэд хамгаалалтай холбоотой зөвлөмжийг жилдээ давхардсан тоогоор 873.2 мянган иргэнд хүргэжээ.

Түр хамгаалах байранд 2019-2023 онд давхардсан тоогоор нийт 198 үйлчлүүлэгч авч 1069 хоногийн үйлчилгээ үзүүлжээ. Нийт үйлчлүүлэгчийн 5 хувь нь насанд хүрэгч эмэгтэй, 95 нь 0-18 насны хүүхэд байсан бол нийт үйлчлүүлэгчийн кейсийг үзэхэд 60.7 хувь нь гэр бүлийн хүчирхийлэл, 39.3 хувь нь хүүхдийн эрх хамгааллын кейс байна.

Түр хамгаалах байраар үйлчилгээ авсан нийт үйлчлүүлэгчийн 89.2 хувийг бүрэн шийдвэрлэж ар гэр харьяа хамтарсан багт нь хүлээлгэн өгсөн бол 10.8 хувь нь цагдаа, шүүхийн байгууллагатай шилжүүлсэн байна.

Удаа дараагийн үл хайхрах хүчирхийлэлд өртсөн, асран хамгаалагч нь орон гэргүй болсон 2 хүүхэд 110 хоногийн багц үйлчилгээ авсан бөгөөд асран хамгаалагчийн эх байх эрхийг шүүхээр хязгаарлаж, төрсөн ахад нь хүлээлгэж өгөн хариу үйлчилгээ үзүүлэн хараа хяналттай ажиллаж байна.


Цагдаагийн газарт бүртгэгдсэн насан хүрээгүй хүүхэд гэмт хэрэгт хохирсон, гэм хэрэгт холбогдсон хүүхдийг гэмт хэргийн төрлөөр нь авч үзвэл:

Хүснэгт №7 Цагдаагийн газарт бүртгэгдсэн насанд хүрээгүй хүн хохирсон гэмт хэрэг

№	Гэмт хэргийн төрөл	2019	2020	2021	2022	2023
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	2		1	2	
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	9	3	8	6	9
3	Хүчиндэх	10	11	7	12	7
4	ЗТО хөдөлгөөний аюулгүй байдал	2	2	6	5	5
5	Хулгайлах	1			1	2
6	Бусад		1	5	11	4
	Нийт	24	17	27	37	27

Графикаар хохирсон хүүхдийг хувьчилж харуулбал

График №2




Цагдаагийн газарт хохирогчоор бүртгэгдсэн 0-18 оны хүүхдийн бүртгэлийг 5 жилээр үзэхэд хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг болон хүчиндэх хэргүүд голчлон тохиолдож байгаа нь багсаагүй үзүүлэлттэй байгаа нь урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулалт дутагдалтай байгаагаас шалтгаалж гэмт хэргийн хохирогчийн тоо буурахгүй байна.

**Насанд хүрээгүй хүн холбогдсон гэмт хэргийн эрүүгийн
хуульд заасан бүлгээр авч үзвэл**

Хүснэгт №8

№	Гэмт хэргийн төрөл	2019	2020	2021	2022	2023
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг			1		
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	6	3	5	6	3
3	Хүчиндэх	3	4	1		1
4	ЗТО хөдөлгөөний аюулгүй байдал		1			1
5	Хулгайлах	5	3	6	14	8
6	Малын хулгай	3				1
7	Бусад		3	1	5	1
	Нийт	17	14	14	25	15

График №3




Графикаас харахад 2019, 2022 онд гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн тоо өндөр байна. Насанд хүрээгүй хүүхдийн зонхилох гэмт хэрэг нь хулгайлах хэрэгт холбогдолт их ажиглагдаж байна.

Энэ нь эцэг эх асран хамгаалагчийн хараа хяналт, хүүхдийн байгууллага, цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол хийж, эцэг эх асран хамгаалагчийн нөлөөллийн ажил дутагдаж байгаатай холбон үзлээ.

Булган аймгийн хүүхдийн эрхийн хууль зүйн хороог аймгийн Засаг даргын 2017 оны А/191 тоот захирамжаар 13 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж жил бүр биелэлтийг тооцож ажиллажээ.

График №4



Үүнээс үзэхэд аймгийн хүүхдийн эрхийн хороо жил бүр төлөвлөгөөний биелэлтийг хангалттай сайн үнэлүүлдэг ч гэлээ хүүхдийн эрхийг хамгаалах, гэмт хэрэг, хүчирхийлэл, үл хайхрах байдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хангалтгүй хэрэгжүүлсэн байна гэж харж байна.

Цагдаагийн газарт гэмт хэрэгт холбогдсон, хохирсон хүүхдэд Хүүхэд, Гэр бүл, хөгжил хамгааллын газраас Хууль ёсны төлөөлөгчөөр оролцуулдаг. Үүнд:

- Эцэг эх асран хамгаалагч нь хүүхдээ хохироосон
- Хүүхдээ хайхрахгүй хаясан, холбоогүй болсон
- Эцэг эхийн хүсэлтээр гэсэн шалтгаанаар цагдаагийн газарт бүртгэгдсэн хүүхдэд хууль ёсны төлөөлөгчөөр оролцож хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг байна.

График №5



Графикаас үзэхэд Цагдаагийн газарт бүртгэгдсэн насанд хүрээгүй хүүхдийн тоо жил ирэх бүрд нэмэгдэж нөхөн сэргээх, хамгааллын үйлчилгээ нэмэгдсэн үзүүлэлтэй байна.

Дүгнээд үзэхэд гэмт хэрэгт холбогдож, хохирч байгаа, гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгаа, эцэг эх, асран хамгаалагч нь хайхрахгүй байгаа энэ кейс нь анх удаа, давхардсан тоогоор гэх мэт үүсэж байгаа нь ХГБХХГ, ЦГ, ЭМГ гэх хүүхэд хамгаалалтай холбоотой байгууллагын урьдчилан сэргийлэх арга хэмжээ хангалтгүй байна

2.1.3 Хүүхэд хамгааллын чиглэлээр урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх, хариу үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа явуулахад 2019-2023 онуудад хүүхэд хамгааллын чиглэлээр 2 орон тоо батлагдаж шаардлагатай хүний нөөцийн хүрэлцээ дутмаг, албан хаагчид тогтвор суурьшилгүй, шаардлагатай зардлыг оновчтой хуваарилдаггүй байна.

Хүүхэд, Гэр бүл, хөгжил хамгааллын газар нь нийт 19 орон тоотойгоор батлагдсан ба 2023 оны байдлаар 17 орон тоогоор ажиллаж үүнээс 35 хувь буюу 7 албан хаагч нь 5-аас дээш жил ажилласан бусад нь 1-ээс 4 дахь жилдээ ажиллаж байгаа бол жилд дунджаар 5-аас 6 албан хаагч чөлөөлөгдөж, шинээр томилогдсон нь тус байгууллын албан хаагчид тогтвор суурьшил муутай байгааг харуулж байна. Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/347 дугаар тушаалаар "Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн дүрэм"-д заасны дагуу хүүхдийн эрхийн улсын байцаагчийн орон тоог батлаагүй, Хүүхдийн хөгжил хамгааллын ахлах мэргэжилтэн, Хүүхдийн эрхийг хамгаалах мэргэжилтэн гэсэн 2 орон тоотойгоор хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлсэн байна. Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6040:2019 стандартад зааснаар мэргэжлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, тогооч орон тоогоор ажиллахаас гэрээт үйлчилгээний ажилтан ажиллаж байна.

Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх төсөв санхүү оновчтой хуваарилагддаггүй санхүүжилт нь хүрэлцдэггүй 2019-2021 онуудад урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсөв батлагддаггүй байсан бол хөтөлбөр, арга хэмжээгээр 2022 онд 50.2 сая, 2023 онд 33.0 сая төгрөгийг баталж зарцуулжээ.

Урьдчилан сэргийлэх зардлаас хүүхдийн оролцоо, нийгмийн ажилчид, гэр бүлд чиглэсэн тэмцээн уралдаан гэх аливаа гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зүйлд зарцуулахаар тухайн онд батлагдсан төсөв нь хангалттай хүрэлцдэггүй оновчтой хуваарилдаггүй.

2.2. Хүүхэд хамгаалалд төлөвлөсөн санхүүжилтийн гүйцэтгэл үр дүнтэй байгаа боловч 2019-2021 онуудад зардлын нормативыг мөрдөж ажиллаагүй цаашид санхүүгийн хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

2.2.1 Хүүхэд хамгааллын чиглэлээр зарцуулсан санхүүжилт, хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулжээ.

Хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах байр ажиллуулах, тэдний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, хэм хэмжээг тогтоож мөрдүүлэхэд хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6040:2019 Монгол улсын стандартыг мөрдөн ажиллаж байна.

Үүнтэй холбоотойгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, 27 дугаар хамтарсан тушаалын хавсралт “Хүүхдийн хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив” түр хамгаалан байрлуулах үйлчилгээний зардлыг нэг хүнд ногдох хувьсах зардлаар тооцож олгожээ.

Хүүхэд хамгааллын чиглэлээр 2019 онд нийгмийн бодлогод чиглэсэн хөтөлбөрөөр 61.9 сая, 2020 онд нийгмийн бодлогод чиглэсэн хөтөлбөрөөр 61.9 сая, 2021 онд хүүхэд хамгааллын хөтөлбөрөөр 58.08 сая, 2022 онд эрсдэлийн болон НБҮ хийхэд 6.04 сая, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд 35.9 сая, урьдчилан сэргийлэх үйлчилгээнд 50.1 сая, 2023 онд эрсдэлийн болон НБҮ хийхэд 4.2 сая, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд 82.2 сая, урьдчилан сэргийлэх үйлчилгээнд 32.9 сая төгрөг тус тус зарцуулжээ.

2.2.2 Хүүхэд хамгааллын төсвийн зарцуулалтыг байгууллагын шилэн дансанд ил тод байдлыг ханган ажиллажээ.

Хүүхэд хамгааллын талаар төсвийн зарцуулалтыг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод тайлагнаж хэвшсэн байна. Булган аймгийн Хүүхэд, Гэр бүл, хөгжил хамгааллын газар нь хүүхэд хамгааллын төсвийн тайлан мэдээг хагас бүтэн жилээр Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газарт тайлагнаж, хүүхэд хамгаалалтай холбоотой төсвийг Шилэн дансны тухай хуулийн дагуу сар, улирал бүр мэдээлж байна. Үүнд 2019-2023 онд нийт 300.1 сая төгрөгийн 172 тушаал шийдвэрийг шилэн дансанд байршуулж ил тод байдлыг хангаж ажилласан байна.


Цаашид төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж арга хэмжээний санхүүжилт, зарцуулалтыг гүйцэтгэгч байгууллагаар ил тод тайлагнуулахад анхаарч ажиллах шаардлагатай байна.

2.2.3 Хүүхэд хамгааллын талаар Австрали улсын MNO095 төсөл хөтөлбөрийн хүрээнд түр хамгаалах байр барих төсөл бичиж шалгарснаар 18.7 мянган Австрали долларын буцалтгүй тусламж авчээ.

Австрали улсын элчин сайдын яамнаас санхүүжүүлсэн MNO095 төслийн үйл ажиллагааг Булган суманд зохион байгуулж ХГБХХГ-аас Австрали улсын элчин сайдын яаманд төсөл бичиж шалгарснаар 18,785 австрали долларыг төслийн санхүүжилт авч 2019 онд эхний санхүүжилт 17.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгож 2020 онд 16.9 сая төгрөгийн санхүүжилт олгосноор нийт 34.5 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгож, санхүүжилт олгосон тал буюу Австралийн элчин сайдын яамнаас хийгдсэн ажилтай танилцсан байна.

*Хүүхэд хамгаалах түр хамгаалах байрны дотор
тохижилтын зураг*

Зураг №1



Түр хамгаалах байр нь амрах 3 өрөө, гал тогоо, хүүхдийн хөгжлийн өрөө, ариун цэврийн өрөө, ганцаарчилсан зөвлөгөө өгөх өрөө гэх мэт шаардлагатай нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2.2.4 Хүүхэд хамгааллын цогц үйлчилгээг хүргэсэн байна.

Нийгмийн бүх орчинд хүүхэд хамгаалал нь хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц, мэргэшсэн үйл ажиллагаанаас бүрдэнэ гэж хуульд тусгасан.

Хүүхэд хамгааллыг гэр бүл, боловсролын салбарын, эрүүл мэндийн үйлчилгээний, хэвлэл, мэдээлэл, цахим орчны, олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээний, соёл, спортын үйл ажиллагааны гэсэн салбар байдлаар хуульчилсан.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлагаар Булган аймгийн хэмжээнд хүүхэд хамгаалал үйлдэгдсэн орчноор нь ангилж үзвэл:

Хүснэгт №9 2019-2023 онд 108 дугаарт ирсэн дуудлага

№	Зөрчлийн орчин	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
1	Гэр бүл дэх хүүхэд хамгаалал	30	34	42	62	50

2	Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал	11	4	10	17	13
3	Цахим орчин	1	0	0	1	0
4	Эрүүл мэнд	0	0	1	0	1
5	Олон нийтийн газар	0	5	5	2	0
Нийт дүн		42	43	58	82	64


- ✓ Гэр бүл дэх хүүхэд хамгаалал: ХГБХХГ-аас байгууллагат эцэг эхийн зөвлөлийг байгуулж хагас бүтэн жилээр хүүхэд хамгаалалтай холбоотой хийгдсэн ажлын тайлан мэдээг авч гэр бүлийн орчинд хүүхэд хамгааллыг эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан эерэг нөлөөллийг бий болгож байна.
- ✓ Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал: ЕБС, СӨБ-ын байгууллагыг захирал, эрхлэгчээр ахлуулсан хүүхэд хамгааллын баг хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө гарган, мөрдөж ажилладаг.
- ✓ Эрүүл мэндийн үйлчилгээ дэх хүүхэд хамгаалал: 16 сум 1 тосгоны төвийн 6 багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нар хамтарсан багийн гишүүнээр эрүүл мэнд талаас нь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлдэг.
- ✓ Цахим орчинд хүүхэд хамгаалал: Хүүхдүүд интернэт ба цахим орчинд орох нь нэмэгдэж байгаа нь тэднийг цахим доромжлол, сэтгэл санаа болон бэлгийн хүчирхийлэл, бэлгийн дарамт, мөлжлөгт өртөх эрсдэлд хүргэж байна. Хүүхдэд чиглэсэн гэмт хэрэг, мөлжлөг, хүчирхийллээс сэргийлж, хариу арга хэмжээ авдаг хүүхэд хамгааллын үр дүнтэй нэгдсэн тогтолцоо байхгүй байна. Энэ асуудлаар тодорхой тусгайлсан хүүхэд хамгааллын бодлого, төлөвлөгөө батлагдаагүй боловч хуулийн шинэчилсэн найруулгад бодлогоор тусгагдаж өгөх нь зүйтэй.
- ✓ Олон нийтийн газар хүүхэд хамгаалал: Эцэг эх, асран хамгаалагч нарт хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлыг хүргэж санаатай болон санамсаргүй байдлаас гэмт хэрэгт холбогдох гэх мэт хүүхдийг аюулгүй байлгах сургалт сурталчилгааг хүүхдийн байгууллага хийж байна.

ХГБХХГ-аас хамгаалалтын үйлчилгээ авсан хүүхдэд үзүүлэх үйлчилгээ нь хамгаалах, нөхөн сэргээх, хариу үйлчилгээ, түр хамгаалах байранд байрлаж байгаа хүүхэд болон насанд хүрэгчдэд цогц үйлчилгээг хүргэж байна. Үүнд:

- Хоол хүнс
- Хувцас
- Эрүүл мэнд
- Сэтгэл зүйн үйлчилгээ
- Холбон зуучлах
- Хариу үйлчилгээ /түлээ мод, хүнс, эм, ахуйн хэрэглээ гэх мэт/

Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ авсан хүүхэд, эрсдэлт бүлэгт байгаа хүүхэд

График №6



Графикаас үзэхэд үйлчилгээ авсан хүүхдийн тоо жил ирэх тусам өсөж байгаа шалтгаан нь гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдээ үл хайхрах, гэмт хэрэг буурахгүй байгаагаар холбоотой байна.

Мэргэжлийн удирдлага, зохион байгуулалт, сургалт, хүүхдийн тусламжийн утас зэргийг багтаасан мэргэжлийн тусгай үйлчилгээ үзүүлдэг энэ нь төсвийг харьяа байгууллагадаа тухайлбал аймаг, сумын хүүхэд хамгаалал, хүүхдийн хөгжлийн үйлчилгээнд чиглэсэн төсвийг баталдаг гэвч орон нутгийн энэ төсвөөс маш бага, эсхүл ямар ч төсөв хамтарсан багт, сум, хорооны хүүхэд хамгааллын үйлчилгээнд төсөвлөөгүй, сумын нийгмийн ажилчид сумын төсөв батлахад тодорхой хэмжээний шатахууны зардал тусгуулдаг ч сум бүр зардал тусгуулж чаддаггүй байна.

Хамтарсан баг нь хангалттай санхүүжилтгүйгээс өрх бүрд хүрч НБҮ хийх, эрсдэлт бүлэгт хамаарагдаж байгаа өрхийг 100 хувь тогтоох боломжгүй байна.

2.2.5 Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хүүхдийн хувь хүний нууц бүрэн хамгаалагдахгүй байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн А/173, А/251, А/380 тоот хамтарсан тушаалын гуравдугаар хавсралтын дагуу Нууцлалын гэрээг албан хаагчидтай жил бүр байгуулж, түр хамгаалах байранд нэвтэрсэн хүнд нууцлалын гэрээг байгуулж ажиллаж байна.

Энэхүү гэрээ нь Хувь хүний нууцын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль заасан хувь хүний болон хүүхдийн нэр, төр мэдээлэл, гэр бүлийн амьдрал, эрүүл мэнд, хувийн харьцааны нууц, орон байрны халдашгүй байдал хувийн орон зайгаа хамгаалуулах эрхийг тус тус хуульд зааж хамгаалсан байна.

Түр хамгаалах байранд хамгаалагдаж байгаа хүүхдийн хоол хүнс, хувцас, ахуйн хэрэглээнд шаардлагатай санхүүгийн гүйлгээ хийхэд тухайн хүүхдийн хүчирхийлэлд өртсөн төрлөөр товчилж огноогоор кодолж гүйлгээг хийдэг байна.

Хувь хүний нууц, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх² заалт, 8 дугаар зүйлийн 8.1.2 дэх³ заалт, 35 дугаар зүйлийн 35.5 дах⁴ заалтын дагуу хүүхдийн нууцыг хамгаалан ажиллажээ.

Хүүхэд, Гэр бүл, хөгжил хамгааллын үйлчилгээнд хувь хүний нууцыг хангалттай сайн нууцалж чадаж байгаа сум, багийн хамтарсан багийн хувьд хувь хүний нууцыг хадгалах тал дээр дутагдалтай байна. Иймд сум, багийн нийгмийн ажилтан, хамтарсан багийн гишүүдэд хувь хүний нууц хамгаалах хууль, журмын мөрдөх, хөтлөх баримт бичгийн талаар сургалт зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих шаардлагатай байна.

2.2.6 Хүүхэд хамгааллын үйлчилгээний урьдчилсан сэргийлэх үйлчилгээний төсвийг 2022-2023 онд хөтөлбөр арга хэмжээгээр баталж өмнөх онуудад бөөн дүнгээр баталж байсан бол хариу үйлчилгээ үзүүлэх төсвийг тусгайлан оновчтой хуваарилалт хийж батлаагүй байна.

Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг 2019-2021 он хүртэл хөтөлбөрөөр тусгайлан зааж өгөөгүй бөөн дүнгээр нь баталдаг байсан бол 2022 онд 50.2 сая төгрөгийг хөтөлбөрөөр баталж 50.1 сая төгрөгийг зарцуулсан бол 2023 онд 33.0 сая төгрөгийг хөтөлбөрөөр баталж 32.99 сая төгрөгийг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулсан байна. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний зардлыг тусгайлан салгаж хөтөлбөр арга хэмжээгээр батлаагүй.

- Хүчирхийлэлд өртөхөөс хамгаалах, урьдчилан сэргийлэхэд хүүхэд хамгааллын чиглэлээр салбар хоорондын уялдаа холбоог бэхжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллах
- Урьдчилан сэргийлэх арга хэмжээг чухалчлах хэдий ч хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг загварчлах, өргөжүүлэх, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах нь нэн шаардлагатай байна.
- Хүүхэд хамгааллын салбарт ажиллаж байгаа мэргэжилтэн, алба хаагчдыг чадавхжуулах сургалтад хамруулж цогц үйлчилгээг сайжруулах нь зүйтэй.

Эрсдэлт бүлийн хүүхдийг НБҮ-гээр урьдчилан илрүүлэх хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх хүүхдийг өөрийн гэр бүлд нэгтгэхэд авсан үйлчилгээг үр дүнтэй байлгах тал дээр цогц хариу үйлчилгээ үзүүлэхээр байна.

² 4.1.4.нууцлалыг хамгаалах;

³ 8.1.2.гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авсан, хянан шийдвэрлэж байгаа албан тушаалтан хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний хувийн мэдээллийг нууцлах, задруулахаас урьдчилан сэргийлэх;

⁴ 35.5.Түр хамгаалах байрны байршил нууц байна.

БҮЛЭГ 3. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНД ХЯНАЛТ, ҮР НӨЛӨӨТЭЙ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.

3.1. Хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдал, хууль журмын хэрэгжилтийн талаар судалгаа шинжилгээ хийж, цаашид үйл ажиллагаандаа ашиглах шаардлагатай байна.

3.1.1 Оролцогч талуудын үйл ажиллагааг үнэлж, дүгнэх аргачлал байхгүй, хийж хэрэгжүүлсэн ажлыг эерэг, сөрөг нөлөөллийг тодорхойлсон баримт материал байхгүй байна.

Аймгийн хүүхдийн төлөө зөвлөл нь жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, хүүхэд хамгааллын чиглэлээр оролцогч талуудад хариуцуулан, хүрэх түвшинг тодорхойлон баталдаг байна.

Хүүхдийн төлөө зөвлөлийн 2023 оны төлөвлөгөө, тайланг авч үзвэл 3 зорилт 5 дэд зорилт хүрээнд 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

- Өсвөр үеийнхэнд ээлтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлж, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр 3 арга хэмжээ,
- Хүүхэд ээлтэй, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагааг эрчимжүүлж, нийгмийн хариуцлагыг төлөвшүүлэх чиглэлээр 3 арга хэмжээ,
- Хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих талаар эцэг эх, асран хамгаалагч, багш нийгмийн ажилтны санаачилга, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр 6 арга хэмжээ,
- Хүүхдийн нөхцөл байдлын талаарх судалгааг сайжруулах, хүүхдэд зориулсан мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр 3 арга хэмжээ,
- Хүүхэд нийгмийн бүх орчинд хүчирхийлэлтэй холбоотой эрсдэлээс хамгаалагдах, эрсдэл ойр байгаа, эсхүл эрсдэлд өртсөн хүүхэд, гэр бүлд үзүүлэх тусламж, үйлчилгээг өргөжүүлэх чиглэлээр 4 нийт 19 арга хэмжээг төлөвлөн Эрүүл мэндийн газарт, Онцгой байдлын газар, ХГБХХГ, БШУГ, ГХУСЗ, Цагдаагийн газар зэрэг байгууллагуудад хариуцуулан биелэлтийг үнэлсэн байна.

Хүүхдийн төлөө зөвлөлийн 2023 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хүрэх түвшинтэй харьцуулан 88.9 хувьтай үнэлсэн байна.

Аудитын хамрах хугацаанд "Хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхдийн элч, хүүхдийн эрхийн ажилтны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал"-ыг ГБХХЕГ-ын даргын 2019 А/108, 2019 оны А/145, 2019 А/147 дүгээр тушаалаар баталсан ба үүнд Хүүхдийн төлөө зөвлөл, хүүхдийн элч, хүүхдийн эрхийн ажилтны үйл ажиллагаа хамааралтай байна.

Харин бусад оролцогч талууд болох хамтарсан баг, боловсролын болон төрийн байгууллагуудыг үнэлж, дүгнэх аргачлал байхгүй, үнэлэлт, дүгнэлт өгсөн баримт материал байхгүй байна.

Сарын үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд сумын хамтарсан багийн нарийн бичиг буюу нийгмийн ажилтныг үнэлж бичиг хэргийн материалаар хангаж байна.

Хүүхдийн эрхийг хамгаалахад оролцож буй талуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх аргачлал байхгүй, бодлогыг хэрэгжүүлснээр хүүхдийн хөгжил, нийгэмд бий болсон эерэг, сөрөг өөрчлөлтийг тооцсон, судалсан баримт материал, мэдээлэл аудитад ирүүлсэнгүй.

Цаашид хүүхдэд хамгаалалд оролцож буй байгууллагуудын ажлыг үнэлж дүгнэн эерэг сөрөг нөлөөллийг тооцон цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө хөтөлбөрийг боловсруулдаг байх шаардлагатай байна.

3.1.2 Аймгийн хэмжээнд ХГБХХГ-аас хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдал, хууль журмын хэрэгжилтийн судалгаа, хяналт-үнэлгээ хийдэггүй байна.

Хүүхдийн эрхийн зөрчил, хамгааллын талаар гарсан дуудлага мэдээллийн дагуу аймаг, сум, багийн нийгмийн ажилтан газар дээр очиж танилцан хүүхдийн эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээний маягтаар үнэлгээг хийж, цагдаагийн байгууллагаас аюулын зэргийн үнэлгээний тэмдэглэл үйлдэж хариу арга хэмжээний шийдвэр гаргадаг байна.

Булган аймагт 2019-2023 онд хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын зөрчлийн талаар хүүхдийн тусламжийн 108 утсанд нийт 289 дуудлага, аймгийн цагдаагийн газарт бүртгэгдсэнээс хүүхэд хохирсон 132, хүүхэд хэрэгт холбогдсон 83 хэрэг байна. Үүнээс хүүхэд хохирсон 132 хэргээс 25 хүүхэд нас барж, 107 хүүхэд гэмтсэн байна.

ХГБХХГ нь хүүхэд хамгааллын тухай хуулиар хүүхдийн эрхийн хэрэгжилт, хүүхэд хамгааллын нөхцөл байдал, тухайн жилд хэрэгжүүлсэн ажлын талаар жилд нэгээс доошгүй удаа олон нийтэд мэдээлэх, нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхэд хамгааллын талаарх мэдээлэл, судалгаанд нэгдсэн дүгнэлт хийхээр заасан байдаг.

"Хүүхдийн төлөө зөвлөл, хүүхдийн элч, хүүхдийн эрхийн ажилтны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн, хүүхдийн эрхийн байцаагч нарын ажилд 2019 онд ХТЗ, хүүхдийн элч, хүүхдийн эрхийн ажилтны үйл ажиллагаанд 2020 онд түр хамгаалах байрын үйл ажиллагаанд тус тус хяналт шинжилгээ үнэлгээ хийжээ.

Харин ХГБХХГ нь бүртгэгдсэн дуудлага, хэрэг зөрчлийн талаарх нөхцөл байдалд судалгаа, шинжилгээ хийж цаашид хийх ажлын чиглэлийг тодорхойлсон баримт материал байхгүй энэ чиглэлийн ажил хийгээгүй нь хүүхэд хамгааллын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 “Орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллагын нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.” 19.1.3-д “нөхцөл байдлын үнэлгээ хийж, дүгнэлт гаргах,” 19.1.6-д “эрсдэлт нөхцөлд байгаа, хууль зөрчсөн хүүхдийн талаар бүртгэл, судалгаа хийх, орон нутгийн хүүхэд хамгааллын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх.” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аудитын явцад сүүлийн 5 жилээр хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлагын нөхцөл байдлыг авч зөрчлийн 75.4 хувь нь гэр бүлийн орчинд, 19.0 хувь нь боловсролын орчинд, 4 хувь нь олон нийтийн газар гарсан байна.

Хүснэгт № 9 Хүүхдийн тусламжийн 108 утасны дуудлага

Зөрчлийн орчин	2019	2020	2021	2022	2023
Гэр бүл дэх хүүхэд хамгаалал	30	34	42	62	50
Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал	11	4	10	17	13
Цахим орчин	1			1	
Эрүүл мэнд			1		1
Олон нийтийн газар		5	5	2	
Дүн	42	43	58	82	64

Дуудлагын сүүлийн 2 жил буюу 2022, 2023 оны дуудлагыг хэлбэрээр авч үзэхэд гэр бүл орчинд үл хайхрах 22, бие махбодын 15, сэтгэл санааны 11, ялгаварлан гадуурхалт 5, бэлгийн хүчирхийлэл 3, үе тэнгийн дээрэлхэлд 4 зэрэг хэрэг зөрчлүүдтэй холбоотой дуудлага ирсэн байна. Уг гэмт хэрэг зөрчлийн дийлэнх хувийг архидан согтуурал, архины хамаарлаас шалтгаалан гарсан байна.

Иймд хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдал, хууль журмын хэрэгжилтийн дагуу өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж, тогтмол судалгаа шинжилгээ хийж, үйл ажиллагааг төлөвлөх шаардлагатай байна.

Харин аймгийн Цагдаагийн газарт бүртгэгдсэн хүүхэд хохирсон, холбогдсон хэрэг зөрчлийн шалтгаан нөхцөл байдлыг тодорхойлж, урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөн ажилласан байна.

3.1.3 Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр олон улсын байгууллагуудаас өгсөн зөвлөмжийн талаар орон нутгийн хүүхдийн байгууллагаас хэрэгжилт гаргасан баримт бичиггүй байна.

3.1.4 Хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжсэн төсөл нь үр дүнтэй ажил болсон байна.

Австрали улсын MNO095 төсөлд ГБХЗХГ шалгарч 34.5 сая төгрөгийн буцалтгүй тусламж авч түр хамгаалах байр барьж ашиглалтад оруулсан байна. Тус байр нь амрах 3 өрөө, гал тогоо, хүүхдийн хөгжлийн өрөө, ариун цэврийн өрөө, ганцаарчилсан зөвлөгөө өгөх өрөө гэх мэт шаардлагад нийцсэн байна.

Түр хамгаалах байранд 2019-2023 онд давхардсан тоогоор нийт 198 үйлчлүүлэгчид 1069 хоногийн үйлчилгээ үзүүлжээ. Нийт үйлчлүүлэгчийн 95 нь 0-18 насны хүүхэд байна.

3.1.5 Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл нь 2023 онд аймгийн хэмжээнд 22 сургууль, 22 цэцэрлэгүүдийн хүүхэд хамгааллын үйлчилгээ, бодлого, төлөвлөгөө, хэрэгжилтэд хяналт тавьж зөвлөгөө өгч ажиллажээ.

Аймгийн түвшинд Хүүхэд хамгааллын нэгдсэн бодлого байхгүй, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичгийн дагуу аймгийн 68 төсөвт байгууллага хүүхэд хамгааллын бодлого боловсруулсан мөрдөж ажиллаж байна.

Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл нь 2023 онд аймгийн хэмжээнд 22 сургууль, 22 цэцэрлэгүүдийн хүүхэд хамгааллын үйлчилгээ, бодлого, төлөвлөгөө, хэрэгжилтэд хяналт тавьж зөвлөгөө өгч ажилласан байна.

3.1.6 Аймгийн хэмжээнд 68 байгууллага хүүхэд хамгааллын бодлоготой ба хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг бодитой үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлал байхгүй байна.

Аймгийн хэмжээнд 68 байгууллага хүүхэд хамгааллын бодлоготой ба хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг бодитой үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлал, хуулийн заалт байхгүй тул хяналт шалгалт хийж үнэлэх боломжгүй байна.

Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого чиглэлийн дагуу” аймгийн хэмжээнд эцэг эхийн зөвлөл байгуулсан 98 төсөвт байгууллага байгаа ба “Байгууллага аж ахуйн нэгжийн дэргэд эцэг эхийн зөвлөл байгуулж ажиллуулах зөвлөмж”-ийн 5.3 дэхь “Жилийн үйл ажиллагааны тайлангаа Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 12 дугаар сарын 01-ны дотор ирүүлж байна.” гэсэн заалтыг мөрдөж 2019 онд 19, 2020 онд 30, 2021 онд 26, 2022 онд 28, 2023 онд 68 байгууллага тайлангаа ирүүлсэн байна. Аймгийн ХГБХХГ-аас эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээ авч 2020, 2021, 2022, 2023 онуудад шилдэг эцэг эхийн зөвлөл шалгаруулж шагнасан байна.

3.1.7 Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг бодитой үнэлж нийгэмд гарч буй эерэг нөлөөг тооцож үнэлээгүй байна.

Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл нь 2023 онд аймгийн хэмжээнд 22 сургууль, 22 цэцэрлэгүүдийн хүүхэд хамгааллын үйлчилгээ, бодлого, төлөвлөгөө, хэрэгжилтэд хяналт тавьсан боловч, үр дүнг бодитой үнэлж нийгэмд гарч буй эерэг нөлөөг тооцож үнэлгээ хийгээгүй байна.

3.2 ГЭР БҮЛИЙН ОРЧИНД ҮЙЛДЭГДЭЖ БАЙГАА ХҮҮХДИЙН ЭРХ, ХАМГААЛЛЫН ЗӨРЧЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР СУРГАЛТ, НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

3.2.1 Хүүхдийн эрх, хамгааллын зөрчлийн 75.4 хувь нь гэр бүлийн орчинд гарсан байна.

Эцэг, эх, гэр бүлийн гишүүд, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхэдтэй холбоотой эрх, үүргээ урвуулан ашиглах, хүүхдийг үл хайхрах, дарамт,

хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, аливаа гэмт хэрэг, зөрчлөөс хамгаалах зохицуулалттай.

Булган аймагт 2019-2023 онд хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын зөрчлийн талаар хүүхдийн тусламжийн 108 утсанд нийт 289 дуудлага бүртгэгдэж үүнээс 218 дуудлага буюу 75.4 хувь нь гэр бүлийн орчинд үйлдэгдсэн үл хайхрах, зодож гэмтээх, загнах, гэрээс хөөх гэсэн дуудлагууд гарсан байна.

Гэр бүлийн орчинд үйлдэгдэж буй хүчирхийллийг бууруулах, гэр бүлийн боловсрол олгох, хандлага зан үйлд нь нөлөөлөх, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр 2019 онд “Гэр бүлийн үнэ цэнэ” сургалт зохион байгуулж төрийн байгууллагын 166 албан хаагчид, 2022 онд “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сургалтыг 2334 иргэнд, “Гэр бүлийн харилцаа”, “Жендер”, “Жендерт суурилсан хүчирхийллийг таних”, “Гэр бүлийн санхүүгээ төлөвлөх нь”, “Хүүхдийн хүмүүжилд эцэг эхийн оролцоо” зэрэг сургалтуудад 3154 иргэн, “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сургалтад 416 иргэнийг тус тус хамруулсан байна.

Байгууллагын эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан гэр бүлийн орчин дах хүүхэд хамгааллыг нэмэгдүүлэхээр Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэлийн батлах тухай” тогтоолын дагуу аймгийн хэмжээнд эцэг эхийн зөвлөл байгуулсан 98 төсөвт байгууллага, Хүүхэд хамгааллын бодлоготой 68 төсөвт байгууллага байна.

Хүүхдийн суурь эрхийг хамгаалах, хүүхдэд ээлтэй орон нутаг, байгууллага хамт олныг бий болгох, эцэг эхийн зөвлөлүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор 2022 онд шилдэг эцэг эхийн зөвлөл шалгаруулах болзолт уралдааныг зохион байгуулж, шалгаруулсан байна.

Эцэг эхийн зөвлөлүүд нь ХГБХХГ-т жилийн ажлын тайлангаа 2019 онд 19 байгууллага өгч байсан бол 2023 онд 68 байгууллага болж өссөн, тухай байгууллагын хүүхдийн хамгааллын талаарх ажил, хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна.

3.2.2 Аймгийн боловсролын салбарын байгууллагууд хүүхдэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн ажиллажээ.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйл, Боловсрол соёл, спортын сайдын 2018 оны “Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлого”, БШУС-ын 2022 оны А/453 дугаар тушаалаар баталсан “ЕБС, дотуур байрын орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”, БСШУСС-ын 2020 оны А/269 дүгээр тушаалаар баталсан “Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлого” батлагдаж эрх зүйн зохицуулалтууд бий болж сургууль, дотуур байрны орчинд сурагчдыг аливаа болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх хамгаалах, мэдээлэл авах, хариу үйлчилгээ үзүүлэх нэгдсэн тогтолцоо бүрджээ.

Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын 22 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 23 цэцэрлэг үйл ажиллагаа явуулдаг бөгөөд бүх сургууль, цэцэрлэгт захирал, эрхлэгчээр ахлуулсан 45 хүүхэд хамгааллын баг ажиллаж байна.

Хүснэгт №10 Боловсролын салбарт иргэдээс ирсэн санал, гомдол дуудлага кейсийг дараах байдлаар ангилан гаргасан байна.

№	Он	Өргөдөл	Кейс	Дуудлага	БШУГ 108	ХГБХХГ 108	Зөрчлийн
1	2021	18	7	5	7	9	2
2	2022	23	8	2	8	15	5
3	2023	3	5	2	5	12	1

Дээрх гомдол, дуудлага, зөрчилтэй уялдуулан жил бүр эцэг, эх сурагч анр сургалт нөлөөллийн ажлууд зохион байгуулж давхардсан тоогоор жил бүр дунджаар 7000 эцэг эх, 23000 сурагч хамрагдсан байна.

Тухайлбал сурагчдын дунд ахуй орчин, гэмт хэрэг, гэр бүл сургуулийн орчны дээрэлхэлт, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулж 2444 багш, 7020 сурагч, 23254 сурагч хамрагдаж, мэргэжлийн зөвлөн туслах үйл ажиллагааг нийт 16 суманд хүүхэд хамгаалал, багшийн ёс зүй, охид хөвгүүдийн эрүүл мэнд зэрэг мэдээллийг өгчээ.

3.2.3 Эрүүл мэндийн салбарт хүүхэд хамгааллын талаар хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан тоо, мэдээлэл байхгүйтэй холбоотой үнэлэх боломжгүй байна.

Эрүүл мэндийн салбар нь Хүүхэд хамгааллын тухай хуулиар Эрүүл мэндийн ажилтан ажил, үүргээ гүйцэтгэх явцдаа эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн тохиолдолд холбогдох байгууллагад мэдээлэх, хүүхдийн, түүний гэр бүл, хувийн нууцад хамаарах мэдээллийг хадгалах, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хуульд заасны дагуу үзүүлэхээр зохицуулсан.

Аймгийн хэмжээнд 16 сум, 1 тосгон аймгийн төвийн 6 баг нийт 23 хамтарсан багийн бүрэлдэхүүнд тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нар ажиллаж байна.

Аймгийн эрүүл мэндийн газрын дарга бөгөөд Хүүхдийн төлөө зөвлөлийн гишүүний хувьд аудитын баг уулзалт, ярилцлага хийхэд эрүүл мэндийн салбарын хүүхэд хамгааллын бодлого, төлөвлөгөө байхгүй, хүүхдийн төлөө зөвлөлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлдэг, гарсан хэрэг зөрчлийн талаарх тоо мэдээлэл нэгтгэсэн байдлаар гаргадаггүй, эрсдэлд нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлсэн үйлчилгээний талаарх мэдээлэл байхгүй хамтарсан багт орж ажиллаж байгаа гэснээс өөр мэдээллийг аудитад ирүүлээгүй.

Хүүхдийн төлөө зөвлөлийн жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтээс эрүүл мэндийн салбартай холбоотой зарим арга хэмжээг авч үзлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан сургалт нөлөөллийн ажлын хүрээнд эерэг хандлага-Эрүүл залуу үе” сургалт нөлөөллийн аяныг хүүхэд ХГБХХГ-тай хамтран ЕБС, МСҮТ-ийн нийт 240 сурагчдад өсвөр насны сэтгэл зүйн онцлог БЗДХ, гэр бүл төлөвлөлт зэрэг сургалтад 6-12 ангийн 2150 хүүхдийг хамруулжээ.

Засгийн газрын 2018 оны 255 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл шүд-эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөрийн хүрээнд цэцэрлэгийн 2-5 насны 1856, ЕБС-ийн 3549 үзлэгт хамруулжээ.

Өсвөр үеийнхний эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт МСҮТ-ийн 57 оюутан, ЕБС-ийн 6-12 насны 1871 нийт 1928 хүүхдийг хамруулж 42 оюутан, сурагчдад эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлсэн байна.

3.2.4 Хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчин дахь хүүхэд хамгааллыг эрчимжүүлэх, энэ чиглэлийн ажлыг нэмэгдүүлэхэд холбогдох зардал тусгаагдаагүй байгааг анхаарах шаардлагатай байна.

Хүүхэд хамгааллын тухай хуульд хүүхдэд зориулсан мэдээ, мэдээллийг хууль ёсны төлөөлөгчөөр дамжуулан олон нийтэд мэдээлэхээр заасны дагуу Булган аймагт үйл ажиллагаа явуулдаг “Сайхан Монгол” тв-тэй гэрээ байгуулан 2020-2023 6.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүүхэд хамгааллын чиглэлээр урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдэлээс хамгаалах телевизийн контентыг тогтмол хуваарийн дагуу иргэд олон нийтэд мэдээлж, мөн гэр бүлийн радио 106.5 FM-ээр гэр бүлийн аюулгүй байдал, хүүхэд хамгаалалтай холбоотой зөвлөмжийг жилдээ давхардсан тоогоор 873.2 мянган иргэнд хүргэжээ.

2022 онд Булган аймагт үйл ажиллагаа явуулж буй хэвлэл мэдээллийн ажилтнуудад "Хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал" сэдэвт сургалтыг өмгөөлөгчтэй хамтран зохион байгуулж 9 ажилтан хамрагдсан байна.

3.2.5 Олон нийтийн арга хэмжээд оролцож буй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс оролцуулах талаар зөвшөөрлийн хуудас авдаг ч архивын нэгж болгон хадгалаагүй байна.

Соёлын салбарын хүүхэд хамгааллын бодлогыг 2022 онд баталсан, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, Хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Соёл, урлагийн газрын даргын хамтарсан 2022 оны А/242, А/76 тушаалаар баталсан "Соёл спорт, олон нийтийн арга хэмжээнд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журам"-ын хэрэгжилтийг ханган ажиллажээ.

Хүүхэд хамгааллын бодлого, төлөвлөгөө түүний хэрэгжилтийг хангах, урлагийн тоглолт, соёлын үйлчилгээ, олон нийтийг хамарсан арга хэмжээний үед хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр 2022-2023 онд хийж хэрэгжүүлсэн ажлыг хамрууллаа.

Олон улс, аймгийн хэмжээнд зохион байгуулсан уралдаан, тоглолтод 2022 онд 3 арга хэмжээнд 1223 хүүхэд, 2023 онд болсон 6 арга хэмжээнд 1085 хүүхэд оролцсон байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулиар соёл, спортын үйл ажиллагаа, урлагийн тоглолт, спортын тэмцээн, бусад арга хэмжээнд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр оролцуулах, хичээл сургалтын үйл ажиллагааг тасалдуулахгүй байх хуулийн зохицуулалттай.

Оролцогч хүүхдүүдийн эцэг, эх, багш нарт хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын журмыг танилцуулан цахим сургалтыг зохион байгуулж арга зүйн зөвлөгөөг өгч аймгийн Засаг дарга, сумдын засаг дарга нарт уралдаан тэмцээнд оролцох хүүхдүүдэд дэмжлэг үзүүлэн ажиллах, Соёл урлагийн газраас оролцох хүүхдүүдийн сургуулийн захиргаанд хүсэлт хүргүүлэн сургалтын үйл ажиллагаанаас чөлөөлөх хүсэлтийг хүргүүлдэг байна.

Гэвч эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс уралдаан, тоглолтод оролцуулах талаар бичгээр авсан зөвшөөрөл, сургалтын үйл ажиллагаа, хоцрогдол арилгах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажилд эцэг эхээс зөвшөөрлийн хуудас авдаг ч баримт материалыг архивын нэгж болон хадгалаагүй байна.

Соёлын салбарын байгууллагууд хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр дараах сургалт, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулжээ.

Хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, хүмүүжлийн эерэг арга гэр бүлийн харилцааны чиглэлээр сургалт, эерэг хандлагыг нийгэмд төлөвшүүлэх нөлөөллийн ажлын хүрээнд бүх нийтийн соёлын боловсрол, соёлын өв, Хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал хувь хүний хөгжил, сэтгэл зүйн боловсрол чиглэлээр 95 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 17 мянган хүүхэд хамруулсан байна.

3.2.6 Гамшгаас хамгаалах тусгай зориулалтын мэргэжлийн ангид нийгмийн хамгааллын мэргэжлийн анги байгуулж сургалт, дадлагын ажилд хамруулсан байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны Мэргэжлийн анги байгуулах тухай А/257 дугаар захирамжаар гамшгаас хамгаалах тусгай зориулалтын мэргэжлийн ангид нийгмийн хамгааллын мэргэжлийн анги байгуулсан байна. Тус анги нь гамшгийн үеийн хүүхэд хамгааллыг хариуцан ажиллах чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд гамшигт өртсөн, орсон хүүхдүүдийг сүүлийн 5 жилээр авч үзвэл голын усанд цөмөрч осолдсон 8, гал түймэрт гэмтсэн 2, нэрвэгдсэн 4, эсэн мэнд олдсон 3 хүүхэд байна.

Хүснэгт № 11 Гамшиг, осолд өртсөн хүүхдийн судалгаа

№	Сумын нэр	он	Гамшгийн төрөл	Гэмтсэн, нэрвэгдсэн хүн
---	-----------	----	----------------	-------------------------

				нас	тайлбар
1	Хангал сум Хялганат тосгон	2019	Голын мөс цөмөрсөн	5	нэрвэгдсэн
2	Орхон сум	2019	Голын усанд осолдсон	17	нэрвэгдсэн
3	Орхон сум	2019	Голын усанд осолдсон	18	нэрвэгдсэн
4	Орхон сум	2019	Голын усанд осолдсон	17	нэрвэгдсэн
5	Хутаг-Өндөр сум	2020	Голын усанд осолдсон	17	нэрвэгдсэн
6	Сэлэнгэ сум	2020	Гал түймэрт	1.5	гэмтсэн
7	Сэлэнгэ сум	2020	Гал түймэрт	2 сар	гэмтсэн
8	Сэлэнгэ сум	2022	Голын усанд осолдсон	4	нэрвэгдсэн
9	Сэлэнгэ сум	2022	Голын мөс цөмөрсөн	4	гэмтсэн
10	Сэлэнгэ сум	2022	Гал түймэрт	6	нэрвэгдсэн
11	Тэшиг сум	2022	Гал түймэрт	6	нэрвэгдсэн
12	Тэшиг сум	2022	Гал түймэрт	4	нэрвэгдсэн
13	Тэшиг сум	2022	Гал түймэрт	2	нэрвэгдсэн
14	хялганат	2023	Голын усанд осолдсон	13	нэрвэгдсэн
15	Орхон сум	2023	Эсэн мэнд олдсон	5	Жимс түүж яваад төөрсөн
16	Орхон сум	2023	Эсэн мэнд олдсон	9	Жимс түүж яваад төөрсөн
17	Орхон сум	2023	Эсэн мэнд олдсон	11	Жимс түүж яваад төөрсөн

Дээрхээс үзэхэд том гол, мөрний орчим байршилтай сум, тосгоны хүүхдүүд гол усны осолд орж нас, барсан гэмтсэн тохиолдол гарсан байна.

Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн ажлыг ХГБХХГ, Цагдаагийн газар, Онцгой байдлын газрууд хамтран “Хүүхдийн аюулгүй байдал-таны хариуцлагаас”, “өсвөрийн аврагч” тэмцээнийг ЕБС, МСҮТ-ийн сурагчдын дунд зохион байгуулсан байна. Мөн өсвөрийн аврагч бүлгэмийг 2 дугаар сургууль, Хутаг-Өндөр, Дашинчилэн сумдын сургуулиудад 40 сая төгрөгийн шийдвэрлэн танхимтай болсон байна.

3.3 ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ СУРГАЛТ, НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

3.3.1 Хүүхдийн эрхийн олон улсын конвенцын талаар сурталчлан таниулжээ.

Хүүхдийн эрхийн конвенц батлагдсан өдрийг 2017 оноос “Дэлхийн хүүхдийн өдөр” болгон тэмдэглэн өнгөрүүлдэг болж энэ өдрийг тохиолдуулан хүүхдийн эрхийн конвенцын хялбаршуулсан хичээлийг аймгийн бүх сургуулиудад нэгэн зэрэг зохион байгуулж 1171 хүүхэд оролцжээ.

Мөн хүүхдийн эрхийн конвенц, хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг хүүхэд багачууд, эцэг эхчүүдэд таниулан мэдүүлэх видео шторк, хүүхэлдэйн өгүүлэмжийг

13 сургууль, 17 цэцэрлэгт хүргүүлэн хүүхэд багачуудад таниулан мэдүүлэх ажил хийгдэж, хүүхэд, өсвөр үеийнхэнд хүүхдийн дээд эрх, ашиг, хүүхдийн эрхийг таниулах, түүнийг эдлүүлэх олон нийтэд сурталчлах зорилгоор “Хүүхдийн эрхийн конвенц-30” дэвжээ тэмцээнийг мөн Булган аймгийн хэмжээнд зохион байгуулжээ.

3.3.2 Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлагад үндэслэн хүүхдийн эрх, хамгаалал ямар орчинд аль төрлийн хэрэг, зөрчил гарч байгаа талаар мэдээлэлд дүн шинжилгээ хийгээгүй байна.

Хүүхдийн тусламжийн 108 утасны дуудлага нь цахим системээр бүртгэгдэж, орон нутгийн ХГБХХГ-ын ажилтан нь бүртгэлийг сум бүрд мэдэгдэж, хамтарсан баг ажиллан шийдвэрлэж байна.

ХГБХХГ-аас 108 утсанд ирсэн дуудлага, мэдээлэлд дүн шинжилгээ хийж хүүхдийн эрх, хамгаалал ямар орчинд аль төрлийн хэрэг, зөрчил гарч байгаа талаар судалсан, түүнд үндэслэн ямар сургалт нөлөөллийн ажил зохион байгуулахаар төлөвлөсөн, хэрэгжүүлсэн зэрэг ажлын баримт материал байхгүй байна.

Аудитын явцад хүүхдийн тусламжийн 108 утасны цахим бүртгэлтэй танилцан, зөрчлийг сум бүрээр, орчин нөхцөл, зөрчлийн ангиллаар авч үзлээ.

Хүснэгт № 12 Хүүхдийн тусламжийн 108 утасны дуудлага сум бүрээр

№	Сумын нэр	Хүүхдийн тусламжийн 108 дуудлага				
		2019	2020	2021	2022	2023
1	Баян-Агт	1	2	2	5	
2	Баяннуур	1	4			
3	Бугат	1	2	6	3	3
4	Булган	11	12	21	31	22
5	Бүрэгхангай	1				3
6	Гурванбулаг	3	4	6	4	2
7	Дашинчилэн	2	4	7	4	5
8	Могод	2		2		1
9	Орхон	2	3		3	3
10	Рашаант		1	4	4	3
11	Сайхан		1	1	1	5
12	Сэлэнгэ	2	2	4	3	2
13	Тэшиг	1			6	5
14	Хангал	4	2	1	8	1
15	Хишиг-Өндөр	1	1	2	6	4
16	Хутаг-Өндөр	5	2	1	4	3
17	хялганат тосгон	5	3	1		2
	Дүн	42	43	58	82	64
	Хуурамч дуудлага		5	2	13	19
	Нийт дүн	42	48	60	95	83

Дуудлагын тоо жил бүр өссөн үзүүлэлттэй нь нэг талдаа зөрчил нэмэгдэж байгаа боловч нөгөө талдаа 108 утасны талаарх мэдээлэл, ойлголт нэмэгдэж байгаатай холбоотой байна.

Хүүхдийн тусламжийн дуудлагын 70-80 хувь нь гэрийн бүлийн орчинд үйлдэгдсэн үл хайхрах, зодож гэмтээх, загнах, гэрээс хөөх гэсэн дуудлагууд гарсан байна.

Гэр бүлийн орчинд үйлдэгдэж байгаа зөрчлийн шалтгааныг бууруулах, дахин өртөхөөс сэргийлж эцэг эх асран хамгаалагчийн хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх зэрэг ажлуудыг үе шаттай урт хугацааны турш хэрэгжүүлэх шаардлагатай байна.

3.3.3 Хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн систем байхгүйгээс хүүхэд хамгааллын үйлчилгээний талаарх мэдээллийг цаг тухай бүрд судлах үр дүнг үнэлэх, цаашид үзүүлэх үйлчилгээг оновчтой төлөвлөхөд бэрхшээл үүсэж байна.

Орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллагын нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан нь эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг судлан тогтоох, бүртгэх, тэдний эрх ашгийг хамгаалах, хариу үйлчилгээнд хамруулах, хууль зөрчсөн хүүхдийн талаар бүртгэл, судалгаа хийх, орон нутгийн хүүхэд хамгааллын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулах чиг үүрэгтэй байна.

Хүүхэд хамгааллын талаарх мэдээ мэдээллийг Able программын бусад хэсэгт эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг бүртгэл үйл ажиллагаандаа ашиглаж байна

Аймгийн хэмжээнд эрсдэлд нөхцөлд орсон хүүхдийн бүртгэл 2019 онд 311 байсан бол 2023 онд 425 болж 114 хүүхдээр өссөн байна.

Хүснэгт № 13 Эрсдэлт нөхцөлд бүртгэлтэй хүүхэд

ОН	Нийт бүртгэгдсэн эрсдэлт нөхцөл дэх хүүхэд	Эрсдэлийн зэрэг			
		Өндөр	Дунд	Бага	Эрсдэлгүй буюу хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж хаасан
2019	311				5
2020	441	439	0	0	2
2021	414	412	0	0	2
2022	414	8	58	78	270
2023	425	14	46	365	0

Эрсдэлд нөхцөлд байгаа хүүхдийн эрсдэлийн төрлөөр авч үзвэл нийт хүүхдийн 365 бага, 46 дунд, 14 өндөр гэсэн бүртгэлтэй байна.

Түр хамгаалах байранд 2019-2023 онд давхардсан тоогоор нийт 198 үйлчлүүлэгчид 1069 хоногийн үйлчилгээ үзүүлжээ.

Түр хамгаалах байраар үйлчилгээ авсан нийт үйлчлүүлэгчийн 89.2 хувийг ар гэр харьяа хамтарсан багт нь хүлээлгэн өгсөн бол 10.8 хувь нь цагдаа, шүүхийн байгууллагатай шилжүүлсэн байна.

үл хайхрах хүчирхийлэлд өртсөн, асран хамгаалагч нь орон гэргүй болон 2 хүүхэд 110 хоногийн багц үйлчилгээ үзүүлж асран хамгаалагчийн эх байх эрхийг шүүхээр хязгаарлаж, төрсөн ахад нь хүлээлгэж өгчээ.

Хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн систем байхгүйгээс хүүхэд хамгааллын үйлчилгээний талаарх мэдээллийг цаг тухай бүрд нь үйлчилгээ үзүүлэгч талуудтай хуваалцах, үр дүнг үнэлэх, цаашид үзүүлэх үйлчилгээг оновчтой төлөвлөх зэрэгт бэрхшээл үүсэж байна.

3.3.4 Бүртгэгдсэн дуудлага, хэрэг зөрчлийн талаарх нөхцөл байдалд судалгаа, шинжилгээ хийж цаашид хийх ажлын чиглэлийг тодорхойлсон баримт материал байхгүй байна.

Аймгийн Цагдаагийн газарт бүртгэгдсэн хүүхэд хохирсон 132, хүүхэд хэрэгт холбогдсон 83 хэрэг бүртгэгдсэн байна. Үүнээс хүүхэд хохирсон 132 хэргээс 25 хүүхэд нас барж, 107 хүүхэд гэмтсэн байна.

Хүснэгт № 14 Насанд хүрээгүй хүн хохирсон гэмт хэргийн тоо, мэдээлэл

№	Гэмт хэргийн төрөл	2019	2020	2021	2022	2023
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	2		1	2	
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	9	3	8	6	9
3	Хүчиндэх	10	11	7	12	7
4	ЗТО хөдөлгөөний аюулгүй байдал	2	2	6	5	5
5	Хулгайлах	1			1	2
6	Бусад		1	5	11	4
	Нийт	24	17	27	37	27

бүртгэгдсэн дуудлага, хэрэг зөрчлийн талаарх нөхцөл байдалд судалгаа, шинжилгээ хийж цаашид хийх ажлын чиглэлийг тодорхойлсон баримт материал байхгүй энэ чиглэлийн ажил хийгээгүй.

Хүснэгт № 15 Насанд хүрээгүй хүн холбогдсон гэмт хэргийн тоо, мэдээлэл

№	Гэмт хэргийн төрөл	2019	2020	2021	2022	2023
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг			1		
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	6	3	5	6	3
3	Хүчиндэх	3	4	1		1
4	ЗТО хөдөлгөөний аюулгүй байдал		1			1
5	Хулгайлах	5	3	6	14	8
6	Малын хулгай	3				1
7	Бусад		3	1	5	1

Нийт	17	14	14	25	15
------	----	----	----	----	----

Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Эрүүл мэндийн газар, Хууль эрх зүйн хэлтэс, Онцгой байдлын газар, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Боловсрол, шинжлэх ухааны газар, Ерөнхий боловсролын 22 сургуулийг хэсэгчилсэн болон нэгдсэн арга хэмжээний хамтран оролцсон байна.

Аймгийн хэмжээнд хүүхэд гэр бүлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа үзүүлж байгаа “Гэрэлт Ирээдүй” төрийн бус байгууллагатай хамтран Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 7-30 хоног баривчлах шийтгэл оногдуулсан 154 иргэнд “Гэр бүлийн үнэ цэнэ”, “Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлог”, “Харилцаа хандлага” зэрэг сэдвээр 8 удаагийн сургалт зохион байгуулан ажилласан. Мөн Булган аймгийн Хутаг-Өндөр суманд үйл ажиллагаа явуулж буй “Бялхам үндэс” төрийн бус байгууллагатай хамтран амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 36 эмэгтэйчүүдэд оёдол, эсгүүрийн сургалтад 30 хоног сургалтад хамруулж ажилласан байна.

3.3.5 Салбар бүр хүүхэд хамгаалалтай холбоотой тоон үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөж, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Аймгийн хэмжээнд хүүхдийн эсрэг хүчирхийллийн шинжтэй дуудлага мэдээлэл тоон үзүүлэлтийг 2019-2023 онуудыг салбараар нь харуулбал:

Хүснэгт № 16 Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн зөрчил

Зөрчлийн орчин	2019	2020	2021	2022	2023
Гэр бүл дэх хүүхэд хамгаалал	30	34	42	62	50
Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал	11	4	10	17	13
Цахим орчин	1			1	
Эрүүл мэнд			1		1
олон нийтийн газар		5	5	2	
Дүн	42	43	58	82	64

Эх сурвалж: Хүүхдийн тусламжийн 108 утасны дуудлагын бүртгэл

Дээрх үзүүлэлтээс харахад гэр бүлийн орчин дахь хүүхдийн хүчирхийлэл нийт хүчирхийллийн 70-80 хувийг эзэлж байгаа нь гэр бүлийн ахуйн архидалт, эцэг эхийн архины хамаарал, ажилгүйдэлтэй холбоотой багийн нийгмийн ажилтан, хамтарсан багууд шаардлагатай арга хэмжээ авч сургалт нөлөөллийн ажил хийж байгаа хэдий ч эцэг, эх асран хамгаалагч сургалт, нөлөөллийн ажилд оролцоо хангалтгүйгээс шалтгаалсан гэж дүгнэлээ.

Эцэг, эх гэр бүлийн гишүүд, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхэдтэй холбоотой эрх, үүргээ урвуулан ашиглах, хүүхдийг үл хайхрах, дарамт, хүчирхийлэл,

мөлжлөгийн бүх хэлбэр, аливаа гэмт хэрэг, зөрчлөөс хамгаалах, түүнийг шийдвэрлүүлэх замаар ээлтэй орчныг бүрдүүлээгүй байна.

Цаашид салбар бүр байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө хүүхэд хамгаалалтай холбоотой, эрсдэлийг бууруулах арга хэмжээ төлөвлөж, үр дүнг тооцож байх шаардлагатай гэж үзлээ.

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитаар цаашид үйл ажиллагаанд мөрдөж ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 9 зөвлөмж өглөө.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Хүүхдийн төлөө зөвлөлийн хуралдсан эсэх, гарсан шийдвэрийн талаар баталгаажуулсан баримт материал байхгүй,
- Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийн бүртгэл судалгаа хангалтгүй, үзүүлсэн үйлчилгээ, гарсан үр дүнгийн талаар дүн шинжилгээ хийгээгүй,
- Аймгийн баяр наадмаас бусад уралдаанд оролцсон уралдаанч хүүхдийн бүртгэл хийгээгүй, программд мэдээлэл оруулаагүй байна.
- Хүүхэд хамгааллын багт ажиллаж байгаа 39 нийгмийн ажилтны 53.8 хувь нь мэргэжлийн бус, хүүхэд хамгаалал, хүүхэдтэй ажиллах анхан шатны нэгжийн хүний нөөцийн хангалтгүй байна.
- Төсвийн төсөл боловсруулахад мөрдөх, аргачлал, журам зааваргүйгээс өмнөх оны гүйцэтгэл дээр үндэслэн төлөвлөж байсан бол 2023 оноос зардлын норматив аргачлал батлагдаж хүүхэд хамгааллын үйлчилгээний зардал 1.6 хувиар өссөн байна.
- Урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж байгаа боловч шаардлагатай төсвийг судалгаанд үндэслэж, тооцож төлөвлөдөггүйгээс урьдчилан сэргийлэх үйлчилгээний төсөв хүрэлцдэггүй байна.
- Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн зөрчлийн дуудлагын 70-80 хувь нь гэр бүлийн орчинд гарсан байна.
- Хүүхэд хамгааллын талаарх зөрчил буураагүй, хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх нь зүйтэй байна.
- Хүүхэд хамгааллын үйлчилгээ, хэрэг, зөрчлийн тоо мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хөтөлбөр боловсруулан, нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- Хүүхэд хамгаалалд оролцогч талуудын ажлын уялдаа холбоо, оролцоо хангалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн дарга, аймгийн Засаг дарга Б.Ариун-Эрдэнэ танаа:

- ✓ Хүүхдийн төлөө зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэр, хуралдааны тэмдэглэлийг баталгаажуулж, архивын нэгж болгох.

- ✓ Салбар хоорондын уялдааг сайжруулах чиглэлд анхаарч оролцогч талуудын хүүхэд хамгааллын талаар хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг хэлэлцэж, үр дүнг тооцдог байх.
- ✓ Аймгийн хүүхдийн төлөө зөвлөл нь төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг ханган тайланг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэх

Аймгийн Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Оюунзаяа танаа:

- ✓ Статистик тоон үзүүлэлт, мэдээ тайланг үнэн зөв гаргах, үзүүлэлт бүрээр дүн шинжилгээ хийж эрсдэлийг тодорхойлон, асуудлыг эрэмбэлж, дарааллын дагуу шийдвэрлэх, мэдээ тайланг албажуулж байх
- ✓ Хурдан морины уралдаан зохион байгуулахад хяналт тавьж байгаа зардлыг хүүхэд хамгааллын зардлаас бус Улсын баяр наадмаас бусад хурдан морины уралдааныг зохион байгуулж байгаа комиссоор гаргуулж уралдаанч хүүхдүүдийн бүртгэлийг хийж, хүүхдийн аюулгүй байдалд хяналт тавьж ажиллах
- ✓ Эрсдэлт бүлгийн хүүхдийн бүртгэлийн программын шинэчлэлийг үр дүнтэй хийх, үйл ажиллагаандаа ашиглах, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн халамж, хамгаалал үйлчилгээний талаар бүртгэл хөтлөх.
- ✓ Урьдчилан сэргийлэх арга хэмжээг гарсан хэрэг зөрчилтэй уялдуулан төсвийг бодиттой судалгаанд үндэслэж, тооцож төлөвлөх
- ✓ Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлага, мэдээллийг холбогдох байгууллага нэн дариу шилжүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ, дүн шинжилгээг хийж, үр дүнгийн мөрөөр шаардлагатай арга хэмжээ авч ажиллах
- ✓ Хүүхэд хамгаалалтай холбоотой арга хэмжээний төлөвлөгөө, тайлан, хувийн хэрэг, холбогдох материалыг байгууллага болон чиг үүргийн дагуу ангилан нууцлалын журмыг хангаж, үдэж архивлах, холбогдох хууль, журмын дагуу архивд хүлээлгэн өгөх

Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар өгсөн зөвлөмжийг биелүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Хавсралт № 1

№	Хэрэгжүүлэх ажил	Хэрэгжилт	хувь
1	Хүүхдийн асуудал сонсох өдрийг зохион байгуулах	Хүүхдийн асуудал сонсох өдрийг 16 сум, 1 тосгон зохион байгуулсан.	100%
2	Бага насны хүүхдийг харж хандах хүнгүйгээр гэрт орхих, үлдээхгүй байхад анхаарч ажиллан, сургалт нөлөөллийн ажлыг эрчимжүүлэх	Бага насны хүүхдийг гэртээ харах хүнгүй үлдээхгүй байх санамж бичгийг цэцэрлэг болон бага ангийн хүүхдийн эцэг эхчүүдэд тарааж, сургалт зохион байгуулсан.	100%
3	Сум орон нутагт ашиглагдаж буй камерын ажиллагаанд хяналт тавьж эвдрэл гэмтлийг холбогдох байгууллагуудын оролцоотой засварлах, чанар стандартыг хангах	Ажлын хэсгээс аймгийн хэмжээнд камерын хяналтын системийн талаар нэгдсэн танилцуулга мэдээллийг Аймгийн ИТХ-н байнгын хороод болон хуралд танилцуулж ИТХ-аас тэмдэглэл гарсан.	70%
4	Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын насны хүүхдүүдийн хамрагдалтын байдалд тандалт судалгаа хийж хамрагдахгүй байгаа хүүхдүүдийн шалтгаан нөхцөлийг тодруулан тогтмол хамрагдалтыг бүрдүүлэх	Бүрэгхангай, Рашаант, Орхон суманд нийт сургууль завсардсан 7 хүүхэд байна. Хүүхдүүдийг сургуульд хамруулах талаар хамтарсан багаас ажил зохион байгуулж 4 хүүхдийг сургуульд буцаан оруулсан.	80%
5	Сум орон нутгийн хэмжээнд байгаа эзэнгүй байшин балгасыг битүүмжилж хүүхэд багачууд орохгүй байх нөхцөлийг бүрдүүлэх, хүүхдэд аюул учруулж болох нүх судаг, цахилгааны ил монтаж, төмрийн хаягдал (газарт зоосон төмөр шон) зэрэг зөрчлүүдийг арилгахад анхаарч ажиллах	2023 оны 11-р сард 16 суманд ажиллаж эрсдэлийн үнэлгээ хийж 215 зөрчил илрүүлж сум бүрд эрсдэлт орчны зураг, орчны тэмдэглэл үлдээсэн. 99 буюу нийт зөрчлийн 20%-ийг газар дээр арилгуулсан. Хамтарсан багууд эрсдэлт нөхцөлийг арилгасан илтгэх хуудсаа илгээсэн ба нийт зөрчлийн 62 хувийг арилгасан байна.	70%
6	Сум орон нутгийн хэмжээнд золбин нохой муур устгалын ажлыг эрчимжүүлж, иргэд олон нийт, хүүхэд багачуудад эргэн мэдээлэх	Сум бүр нохой устгалын ажлыг жилд 2 удаа зохион байгуулдаг. 2023 оны 11-12 сард нохой устгалыг бүгд хийсэн.	100%
7	Хүүхдийн тоглоомын талбайг сэргээн засварлах, тоглоомуудын чанар стандарт бүрэн байдлыг хангаж ашиглалтад хяналт тавьж ажиллах	Аймгийн хэмжээнд байгаа 38 тоглоомын талбайд үзлэг хийж эвдрэл гэмтлийг тэмдэглэлд дурдаж үлдээсэн. Сумдын хамтарсан багууд тоглоомын талбайг засварлах, битүүмжлэн хаах зэргээр хүүхэд эрсдэх нөхцөлийг арилгасан.	70%

8	Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны эргэн тойронд үйл ажиллагаа явуулдаг дэлгүүр, худалдааны төвүүдэд хүүхдэд зарахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүн эд зүйлс худалдан борлуулах явцад хяналт тавих	Хүнс Хөдөө аж ахуйн газрын Хүнсний хяналтын улсын байцаагч сум бүрд шалгалт хийж Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/370 тоот тушаалын дагуу сургууль цэцэрлэгийн орчинд худалдахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүн худалдан борлуулагдаж байгаа эсэхэд хяналт тавьсан. Шалгалтаар сургууль цэцэрлэгээс 150м зайд байрласан худалдааны цэгүүдийн тоо, зөвшөөрөгдөөгүй хүнсний бүтээгдэхүүн зарагдаж байгааг тэмдэглэлд дурдаж орон нутгийн удирдлагад өгсөн	50%
	Нийт хэрэгжилт		80%

Хавсралт № 2

№	Овог нэр	Сумын нэр	Нас	Мэргэжил	Ажилсан жил
1	С.Мягмарсүрэн	Баян-Агт сум	34	Монгол Хятад судлал	3 жил
2	Э.Болд-эрдэнэ	Баян-Агт сумын сургууль	27	Улс төр судлаач	2 жил
3	Л.Оюунгэрэл	Бугат сум	39	Эрх зүй	7 жил
4	Э.Уянга	Булган 1-р баг	35	Био технологич	1 жил
5	Х.Чимгээ	Булган 2-р Баг	36	Англи хэлний орчуулагч	1 сар
6	П.Өлзийсайхан	Булган 4-р баг	39	Банк санхүү, нягтлан	1 сар
7	н.Өнөрбаяр	Булган 5-р баг	37	Уул уурхай инженер	4 сар
8	Б.Сайханбаяр	Булган 6-р баг	41	Бизнес удирдлага	3 жил
9	Э.Ганчимэг	Булган сум	29	Албан хэргийн менежер	2 жил
10	Э. Ариунчимэг	Бүрэгхангай сум	44	Эрх зүйч	3 жил
11	О.Батцэцэг	Гурванбулаг сумын сургууль	35	Бага ангийн багш	2 сар
12	С.Өлзийхутаг	Гурванбулаг сум	55	Удирдлагын менежер	7 жил
13	Буманцэцэг	Дашинчилэн сум	26	Хими багш	2 жил
14	н.Уранцэцэг	Могод сум	34	Орос хэлний багш	8 жил
15	Ц.Хулганаа	Сайхан сум	33	Түүх Нийгмийн Ухааны багш	6 жил
16	н.Өнөрмаа	Сэлэнгэ сум	44	Экологи байгаль судлал	1 жил
17	н.Мөнхтуул	Сэлэнгэ сумын сургууль	24	Эрх зүйч	1 жил
18	Б.Ганчимэг	Тэшиг сумын сургууль	23	Боловсрол судлаач	2 жил
19	н.Цолмон	Хангал сумын сургууль	42	Англи хэлний багш	11 жил
20	Б.Ариунсарнай	Хишиг Өндөр сум	32	Хүмүүнлэгийн ухаан, гадаад харилцааны менежер	8 жил
21	Ц. Уранчимэг	Хутаг-Өндөр сум	42	Япон хэлний багш	2 жил